

Сангийн сайдын тушаалын төсөл

Аргачлал батлах тухай

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг болон Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг үндэслэн Тушаах нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг санхүүгийн тайлагналын зориулалттай дахин үнэлэх аргачлал”-ыг 1-р хавсралтаар, “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-г 2-р хавсралтаар, “Инженерийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”-г 3-р хавсралтаар, “Барилга байгууламжийн үнэлгээг нутаг дэвсгэрийн бүсчлэлээр тооцох итгэлцүүр”-ийг 4-р хавсралтаар, “Нийтийн эзэмшлийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”-г 5-р хавсралтаар, “Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа”-г 6-р хавсралтаар, “Барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргаа”-г 7-р хавсралтаар, “Гадаад улс орон дахь дипломат төлөөлөгчийн газруудын 1 м.кв газрын нэгжийн жишиг үнэ”-ийг 8-р хавсралтаар, “Дахин үнэлгээний хураангуй тайлан”-г 9-р хавсралтаар, “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан”-г 10-р хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, энэ талаар арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т даалгасугай.

Сайд. ...

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ ДАХИН ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ****Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1 дүгээр заалт болон Монгол улсын засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа Монгол Улсын төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны үнэлгээний жишигт нийцүүлэн үнэлүүлж санхүүгийн тайланд тусгах зорилгоор дахин үнэлгээ хийхэд энэхүү аргачлалыг мөрдлөг болгоно.
- 1.2 Энэ аргачлал нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн хөрөнгийг 2018 онд дахин үнэлэх үйл ажиллагааг зохицуулахад нэг удаагийн зориулалтаар ашиглагдана.
- 1.3 Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа талбар газар, газраас салгамагц эдийн засгийн утгаа алддаг барилга, байгууламж зэрэг үл хөдлөх хөрөнгийг энэхүү аргачлалаар үнэлэхдээ бодит үнэ цэнийн суурийг хэрэглэнэ.
- 1.4 Төрийн болон орон нутгийн өмчийн дахин үнэлгээг явуулахад Монгол улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль, Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС) 2017: ҮОУС-ын Онолын Үзэл баримтлал, ҮОУС 101 Ажлын цар хүрээ, ҮОУС 102 Шалган магадлалт ба даган мөрдөлт, ҮОУС 103 Тайлагнал, ҮОУС 104 Үнэ цэнийн сууриуд, ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, ҮОУС 400 Үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоо-г баримтлана.
- 1.5 Төрийн өмчийн дахин үнэлгээний үр дүнг бүртгэл, тайланд тусгахдаа НББОУС-16 "үндсэн хөрөнгө", УСНББОУС 17 "үндсэн хөрөнгө" энэ аргачлал бусад холбогдох журам, зааврыг баримтална.

Хоёр. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд тавигдах шаардлага

- 2.1 Өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий газар, барилга, байгууламж бүрээр салгаж хөрөнгийн төрөл тус бүрээр үнэ цэнийг тодорхойлно.
- 2.2 Үнэлгээний ажлын хамрах хүрээ, хэрэглэх ба хязгаарлах нөхцөл, таамаглалын үндэслэлийг тайландаа тодорхой заах бөгөөд үл хөдлөх хөрөнгийн төрөл тус бүрт *норматив аргыг* хэрэглэнэ.
- 2.3 Үнэлж буй үл хөдлөх хөрөнгийн орчин, өмчлөл, хийц бүтээц, ашиглалтын байдал, зориулалт гэх мэт тухайн хөрөнгийн онцлог, үнэ цэнэд нөлөөлөх хүчин зүйлсийг шинжлэн судлаж үнэлгээний тайланд тусгасан байна.

- 2.4 Санхүүгийн тайлагналын зориулалтаар үл хөдлөх хөрөнгийг үнэлэхдээ бодит үнэ цэнийг сууриа болгон ҮОУС-2017, УСНББОУС-21 “Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт” зэрэг стандартын шаардлагад нийцүүлнэ. Хэрэв үнэ цэнийн бууралт байгаа Төсвийн бус байгууллагын хувьд бол хөрөнгийн дансны үнийг “нөхөгдөх дүн” хүртэл бууруулан тооцож болно. Үнэ цэнийн бууралтын гарзыг УСНББОУС-21-д заасны дагуу тооцоолно.
- 2.5 Дахин үнэлгээний аргачлалд тусгагдсан гадаад улс дахь газрын нэгжийн жишиг үнэ, барилга байгууламжийн бүсийн итгэлцүүр нь үнэлгээний өдрөөрх зах зээлийн мэдээлэлд тулгуурлан тогтоогдсон.

Гурав. Хамрагдах хүрээ

- 3.1 Дахин үнэлгээний ажлын Үнэлгээний Өдөр нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдөр байна.
- 3.2 Дахин үнэлгээний ажилд бэлчээрийн зориулалттай газар, дуусаагүй барилгыг энэ удаагийн дахин үнэлгээнд хамруулахгүй. Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн, хараат бус үнэлгээчнээр үнэлүүлнэ.
- 3.3 Дахин үнэлгээний үр дүнг зөвхөн санхүүгийн тайлан, бүртгэлд тусгах зорилгоор л ашиглана. Худалдан борлуулах, бусдад шилжүүлэх, шүүхийн маргаанд, татварын зорилгоор хэрэглэхгүй.
- 3.4 Дахин үнэлгээнд 2016 оноос хойш үнэлгээ хийгдсэн хөрөнгө хамрагдахгүй.
- 3.5 Барилга байгууламжийн ашиглалтын болон байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтээцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүсэж, илт эвдрэл, гэмтэлтэй, үндсэн бүтээц хийцэд өөрчлөлт оруулсан барилгын элэгдлийг, барилгын бодит үнэ цэнийг хөндлөнгийн, хараат бус үнэлгээчнээр үнэлүүлж болно.
- 3.6 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани хуулийн этгээдэд энэ аргачлал хэрэглэхгүй.

Дөрөв. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ

А. Газрын эрхийн үнэлгээ

- 4.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх Төрийн өмчийн Газрын ашиглах/эзэмших эрхийн үнэлгээг нормативын аргыг ашиглан үнэлнэ.
- 4.2. Газрын нэгжийн жишиг үнийг сонгохдоо Монгол улсын нутаг дэвсгэр дэх Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газрын 2018 оны ...-р тогтоолын 3-6 дугаар хавсралтад заасан Суурь үнэлгээний бүс /зэрэглэл/-д харгалзах суурь үнийг, гадаад улс орон дахь дипломат төлөөлөгчийн газруудын хувьд энэхүү аргачлалын хавсралт 8-д заасан газрын нэгжийн жишиг үнийг сонгон авна.
- 4.3. Газрын эрхийн статусын ялгааны тохируулгыг хийхдээ Өмчлөх эрхийн итгэлцүүр 1 гэвэл Эзэмших эрхийнх 0.88, Ашиглах эрхийнх 0.76 гэж тохируулга хийнэ.

- 4.4. Газрын эзэмших/ашиглах эрхийг дахин үнэлэхдээ гэрчилгээгээр баталгаажсан газрын хэмжээг 4.2-д сонгосон нэгжийн жишиг үнийг 4.3-д тодорхойлсон үнийн өсөлтийн итгэлцүүр, 4.4-д тохирох эрхийн тохируулга, 4.5-д сонгосон газрын бүсийн итгэлцүүрээр тус тус үржүүлэн үнэлнэ.

Жишээ 1. ЧД-ийн Хайлааст дахь 19-р хорооны конторын барилга бүхий 2000 м² хэмжээтэй, худалдаа, үйлчилгээний зориулалттай газрын эзэмших эрхийн үнэ цэнийг тодорхойлье.

а/ Нийслэлийн 6-р бүсэд хамаарч байгаа тул Засгийн газрын ...-р тогтоолд зааснаар 1га-ын суурь үнэ 960.0 сая төгрөг буюу 1 м.кв-ын суурь үнэ 96,000 төгрөг болж байна.

б/ Газрын эзэмших эрхийн үнэ цэнэ $96,000.00 \times 2000 = 192,000,000.00$ төгрөг болов.

Жишээ 2. Дархан-Уул аймгийн 9-р хорооны нутаг дэвсгэр, Хээтэй хороололд байршилтай, Цэцэрлэгийн барилгын 3600 м² хэмжээтэй, газрын эзэмших эрхийн үнэ цэнийг тодорхойлье.

а/ Дархан-Уул аймгийн төвийн бүсэд хамаарч байгаа тул Засгийн газрын 2018 оны ...-р тогтоолын 4-р хавсралтын Дархан-Уул аймаг, Дархан сумын 1-р бүсд Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ зориулалтын 1га-ын суурь үнэ 500 сая төгрөг буюу 1м²-ын суурь үнэ 50,000 төгрөг болно.

б/ Газрын эзэмших эрхийн үнэ цэнэ $50,000.00 \times 3600 = 180,000,000.00$ төгрөг болов.

Жишээ 3. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 1 дүгээр бүсэд эмнэлгийн үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх 6000 м² хэмжээтэй, газрын эзэмших эрхийн үнэ цэнийг тодорхойлье.

а/ Энэ тохиолдолд Засгийн газрын 2018 оны ...-р тогтоолын 6-р хавсралтын Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ зориулалтын 1га-ын суурь үнэ 20 сая төгрөг буюу 1м²-ын суурь үнэ 2,000 төгрөг болно;

б/ Газрын эзэмших эрхийн үнэ цэнэ нь: $2000.0 \times 6000 \text{ м}^2 = 12,000.00$ төгрөг болж байна.

Б. Барилгын үнэлгээ

- 4.7. Барилгын дахин үнэлгээний үндсэн нэгж нь барилгын талбай болно. Барилгын талбайг тогтооходоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцно. Давхар барилгад давхар тус бүрийн талбайн нийлбэрээр нийт талбайг гаргана.
- 4.8. Барилгын зоорийн талбайг уг барилгын инженерийн зориулалттай байгууламж /дулааны узель, г.м/ зориулалтаар ашиглаж тохиолдолд тухайн барилгын нэгж талбайн жишиг үнийн 50 хувиар бодож үнэлнэ.

- 4.9. Нийтийн болон бүрэн цутгамал орон сууцны хувьд Стандарт, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал” MNS6058:2009 стандартын дагуу тооцсон нийтийн болон бүрэн цутгамал орон сууцны цэвэр талбайн хэмжээ /дотор ханаас хана/-г үндэслэн тухайн орон сууцны үнэлгээг тодорхойлохдоо нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 1.10 гэсэн итгэлцүүрээр өсгөнө.
- 4.10. Барилгын гадна ханын гадна гадаргуу хоорондын зайг үндэслэн барилгын нийт талбайг тодорхойлсон үед барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг дараахь итгэлцүүрээр бууруулна. Харин Хавсралт 2-ын “жижиг барилга” ангилалын нэгж тайлбайн жишиг үнэлгээнд ханын зузаанаас хамаарах итгэлцүүрийг хэрэглэхгүй.

д/д	Гадна ханын зузаан	Бууруулах итгэлцүүр
1	510 мм-ийн зузаан хүртэл	0.94
2	640 мм-ийн зузаантай	0.92

- 4.11. Барилгын өндрийг орон сууцны барилгад 3.3м, олон нийт, үйлчилгээний барилгад 3.6м, үйлдвэрийн барилгад 4.5м-ээр нэгжийн жишиг өртгийг тооцсон бөгөөд илүү гарсан 1м тутамд 5%-иар өсгөнө.
- 4.12. Байгалийн хүчин зүйлийн илтгэлцүүрийг БХБ-ын сайдын 2016 оны 85-р тушаалаар батлагдсанаар хэрэглэнэ.

	Зэрэглэл				
	I	II	III	IV	V
Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр	1.00	1,05	1,10	1,18	1,25

- 4.13. Байгалийн хүчин зүйлийн илтгэлцүүрийг хот, суурин газрын 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэнэ.
- 4.14. “Барилгын тухай хууль”-ийн 40.1.24, 10.1.1-д заасан зөвшөөрөл шаардахгүй ангилалд багтах, хот, аймгийн төвийн гэр хороолол, зуслан, сум бригадад аж ахуйн аргаар баригдсан барилгуудыг барилга угсралтын ажлын шууд зардлаар нь тооцох буюу нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 0.75 гэсэн итгэлцүүрээр бууруулж тооцно.
- 4.15. “Жижиг барилга”-аас бусад барилга байгууламжид Хавсралт 4-ийн бүсийн итгэлцүүрийг хэрэглэнэ.
- 4.16. Инженерийн шугам сүлжээний холбогдлын итгэлцүүрийг дараах байдлаар хэрэглэнэ.

Д/д	Төрөл	Итгэлцүүр
-----	-------	-----------

1	Холбогдоогүй, Ердийн пийшин халаалттай	0,75
2	Хагас холбогдсон, Нам даралтын зуухтай	0,85
3	Бүрэн холбогдсон	1,00

- 4.17. Дахин үнэлгээг хийхдээ энэ журмын 4.7-д зааснаар тогтоосон нийт талбайг 1-р хавсралтаас барилгын зориулалт, хийц, хүчин чадалтай уялдуулан сонгосон нэгж талбай, хүчин чадлын жишиг өртгөөр үржүүлэн гадна ханын зузааны, барилгын өндрийн, байгалийн хүчин зүйлийн, инженерийн шугам сүлжээний холбогдлын итгэлцүүр, бүсийн итгэлцүүрээр тус тус үржүүлэн бүрэн орлуулах өртгийг тодорхойлно.
- 4.18. Барилгын хийцийн ангилалын аль ч төрөлд тохирохгүй барилга байвал хамгийн ойролцоо хийцтэйд хамааруулж үнэлнэ.

Ангилал	Даацын хийц, бүтээц	Хана	Хучилт
A	Төмөр бетон арагт бүтээц	Тоосго, блокон дүүргэгчтэй	Цутгамал бетон хучилт
B	Угсармал төмөр бетон	Угсармал төмөр бетон	Угсармал төмөр бетон
C	Холимог (бетон бүс, зүрхэвчтэй) бүтээц	Даацын тоосго, блокон дүүргэгчтэй	Угсармал, цутгамал
D	Даацын өрөгт болон модон холимог бүтээцтэй	Холимог дүүргэгч болон модон	Модон болон хөнгөвчилсэн хавтан
S	Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сандвич/ болон хөнгөвчилсэн бүтээцтэй	Мод болон хөнгөвчилсэн хавтан, Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сандвич/	Мод болон хөнгөвчилсэн хавтан, Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сандвич/

- 4.19. Барилга байгууламжийн элэгдэл (Э)-ийг ч тооцоход дараах чанар байдлын үнэлгээг хэрэглэнэ.

Төлөв байдлын үнэлгээ	Барилга, байгууламжийн чанар байдлын дүгнэлт	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин (Б), %
1 – Хангалттай сайн	Ашиглалтанд ороод удаагүй байгаа “Бараг шинэ” барилга, байгууламж	0-5%

2 – Маш сайн	Барилга, байгууламжийн дотор болон гадна талын жижиг гэмтэл (засвар шаардлагагүй)	5-15%
3 - Сайн	Барилга, байгууламжийн дотор болон гадна талын жижиг гэмтэл (хөнгөн засвар шаардлагатай)	15-30 %
4 - Дунд	Барилга, байгууламжийн дотор болон гадна талын гэмтэл нь хөнгөн засвараас гадна зарим нэг элементийг солих завсар шаардлагатай эсвэл их засвар шаардлагатай. Жишээлбэл, цонх, хаалга, сантехник солих, дээврийн их засвар г.м.	30-50 %
5 - Муу	Барилга, байгууламжид бүхэлд нь их засвар шаардлагатай	50-75 %
6 – Ашиглах боломжгүй	Барилга, байгууламж нь биет байдлаараа ашиглах боломжгүй болсон, сайжруулах эсвэл буулгах шаардлагатай болсон	75-85 %

4.20. Элэгдлийг тухайн барилга, байгууламжийн үндсэн хийц, бүтээцийн Хавсралт 7-д заасан хувийн жинг 4.19-оор тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)	Элэгдлийн хувь (M=A*Б)
1	Үндсэн хийц, бүтээц	A ₁	Б ₁	M ₁
2	Дээвэр	A ₂	Б ₂	M ₂
3	Сантехник	A ₃	Б ₃	M ₃
4	Цахилгаан	A ₄	Б ₄	M ₄
Элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				

4.21. Цаашид ашиглах хугацаа (T_{үлд})-г Хавсралт 6-д заасан хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа (T_{норм}) болон 4.20-д тодорхойлсон Элэгдлийн хувийг ашиглан дараах томъёогоор тооцоолно. Хэвийн ашиглалтын нөхцөлтэй байвал үл хөдлөх хөрөнгийн үр ашигт ашигласан хугацаа нь хуанлийн ашиглалтын хугацаатай тэнцүү байдаг.

$$T_{\text{үлд}} = T_{\text{норм}} * (1 - \text{Э}) \quad (1)$$

4.22. Барилга байгууламжийн ашиглалтын болон байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтээцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүсэж, эвдрэл гарсан бол Элэгдлийн болон Чанарын үнэлгээг экспертийн аргаар тодорхойлно.

Мэргэжлийн байгууллагын гаргасан экспертийн дүгнэлтэд үндэслэн барилга байгууламжийн элэгдэл, цаашид ашиглах (Т_{үлд}) хугацааг тооцоолно.

- 4.23. Элэгдлийн дүнг 4.20-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлно.
- 4.24. Барилга байгууламжийн Бодит үнэ цэнийг 4.17-д тооцоолсон Бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон Элэгдлийн дүн болон Үнэ Цэнийн Бууралтын дүнг хасаж тодорхойлно.
- 4.25. Үнэ цэнийн бууралтын шалгалтыг УСНББОУС-21-д заасны дагуу тооцохдоо ашиглалтын үнэ цэнийг, мөнгө бий болгогч нэгжийг, улмаар үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус, тусгай зориулалтын болон тусгай зориулалтын бус эсэхийг, цаашид ашиглахгүй хөрөнгө бол устгалын өртгийг тус тус тодорхойлно.
- 4.26. Хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Нөхөгдөх дүнг мөнгө бий болгогч хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулалттай холбоотой зардлыг хассан дүн болон ашиглалтын үнэ цэнийн аль ихээр тооцоолно.
- 4.27. Ашиглалтын үнэ цэнийг энэхүү аргачлалд ашиглаж буй аргаар тооцоолно.

ЖИШЭЭ 1. Олон нийтийн барилга

Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд байрлалтай 1989 онд баригдсан, төмөр бетон суурьтай, 510 мм-ын зузаантай тоосгон ханатай, төмөр бетон хучилттай нийт гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар нийт 864 м.кв талбай бүхий соёл үйлчилгээний зориулалттай 1 давхар барилга, барилгын өндөр 3.6 м, цэвэр, бохир усны шугамгүй, зөвхөн дулаанд холбогдсон. Барилгын үндсэн хийц бүтээцэд гарсан нүдэнд ил үзэгдэх ан цав, эвдрэл гэмтэл гараагүй, харин сүүлийн 5 жилийн хугацаанд сантехникийг бүрэн шинэчилсэн, дээвэр болон цахилгааны монтажийг бүрэн солих шаардлагатай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй барилгын хийц бүтээцийн төрөл нь 4.18-д заасны дагуу “С” ангилалд хамаарч байна. Иймээс нэгж үнэлгээг Хавсралт 2-ын “Олон нийтийн барилга” ангилалд байгаа “Соёлын төв”-д харгалзах “С” ангиллын нэгж үнэлгээ 1122.07 мян. ₮-өөр сонгоно.

Барилгыг гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар хэмжсэн тул 4.7-д заасны дагуу барилгын талбайг тогтоохдоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцох тул 4.10-аар 510 мм-ын зузаантай ханатай барилга тул барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 0.94 итгэлцүүрээр бууруулна.

Барилгын өндрийн итгэлцүүр нь 4.11-д заасны дагуу олон нийт, үйлчилгээний барилгын өндөр 3.6 м байхаар нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон бөгөөд бидний үнэлж буй барилгын өндөр 3.6 м байгаа тул 1.0 байна.

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр нь 4.12-д заасны дагуу 4.13-аар 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэхдээ БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд бидний үнэлж байгаа барилга нь 1 давхар барилга тул Говьсүмбэр аймгийн Шивээговь сум нь I зэрэглэлд хамаарч K-1.0 байна.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлын итгэлцүүр нь 4.16-д заасны дагуу үнэлэгдэж байгаа барилга нь зөвхөн дулаанд холбогдсон тул 0.85 байна.

Бүсийн итгэлцүүр Говьсүмбэр аймгийн хувьд Хавсралт 4-д зааснаар 0.67 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.17-д заасны дагуу нийт талбайг нэгж үнэлгээ болон гадна ханын зузааны, барилгын өндрийн, байгалийн хүчин зүйлийн, инженерийн шугам сүлжээний холбогдлын, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$$864.0\text{м.кв} * 1122.07\text{мян. ₮} * 0.94 * 1.0 * 1.0 * 0.85 * 0.67 = 518,985.56 \text{ мян. ₮ байна.}$$

Элэгдлийг тооцох:

Элэгдлийн хувийг 4.19-д заасны дагуу тодорхойлоход бидний үнэлж байгаа барилгын чанар байдал нь дотор болон гадна талын гэмтэл нь хөнгөн засвараас гадна ялангуяа дээвэр, цахилгааны монтажийг бүрэн солих шаардлагатай тул “4-дунд” гэсэн төлөв байдалд хамаарч, хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшинг 30-50%-ийн хооронд байна гэж үзээд 4.20-оор элэгдлийг тухайн барилгын үндсэн хийц бүтээцийн Хавсралт 7-д заасан “соёлын төв” барилгын хувийн жинг 4.19-өөр тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр 36.65% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)	Элэгдлийн хувь (M=A*Б)
1	Үндсэн хийц, бүтээц	85.50%	30%	25.65%
2	Дээвэр	5.40%	100%	5.40%
3	Сантехник	5.00%	30%	1.50%
4	Цахилгаан	4.10%	100%	4.10%
Элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				36.65%

Барилгын цаашид ашиглах хугацаа (T_{үнд})-г 4.21-д заасны дагуу Хавсралт 6-ийн 1.2-оос 13-р мөрийн харгалзах “дундаж” багана дахь ашиглалтын норматив

хугацаа ($T_{\text{норм}}$) 50 жилийг болон 4.20-д тодорхойлсон элэгдлийн хувийг ашиглан тооцоолоход

$$T_{\text{үлд}} = T_{\text{норм}} * (1 - \text{Э}) = 50 * (1 - 36.65\%) = 32 \text{ жил байна.}$$

Элэгдлийн дүн нь 4.20-д заасны дагуу 4.13-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлоход

$$518,985.56 \text{ мян. ₮} * 36.65\% = 190,208.21 \text{ мян. ₮} \text{ байна.}$$

Барилгын Бодит үнэ цэнийг 4.24-д заасны дагуу 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход

$$518,985.56 \text{ мян. ₮} - 190,208.21 \text{ мян. ₮} = 328,777.35 \text{ мян. ₮} \text{ байна.}$$

ЖИШЭЭ 2. Орон сууцны барилга

Сэлэнгэ аймгийн Сайхан суманд байрлалтай 2009 онд баригдсан, угсармал хавтгаалжин бүтээцтэй, 37.78 м.кв цэвэр талбай бүхий 3 өрөөтэй орон сууц, өндөр өндөр 2.4 м, төвийн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон. Барилгын үндсэн хийц бүтээцэд гарсан нүдэнд ил үзэгдэх ан цав, эвдрэл гэмтэл гараагүй, бага зэргийн урсгал засвар хийгдэх шаардлагатай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй орон сууц хийц бүтээцийн төрөл нь 4.18-д заасны дагуу “В” ангилалд хамаарч байна. Иймээс нэгж үнэлгээг Хавсралт 2-ын “Орон сууцны барилга” ангилалд байгаа “Нийтийн орон сууц”-д харгалзах “В” нэгж үнэлгээ 1107.45 мян. ₮-өөр сонгоно.

Орон сууцны талбай нь цэвэр талбайгаар өгөгдсөн тул 4.7-д заасны дагуу орон сууцны талбайг тогтооходоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцох тул 4.9-өөр орон сууцны нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 1.10 итгэлцүүрээр өсгөнө.

Барилгын өндрийн итгэлцүүр нь 4.11-д заасны дагуу орон сууцны барилгын өндөр 3.3 м байхаар нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон бөгөөд бидний үнэлж буй барилгын өндөр 2.4 м байгаа тул 1.0 байна.

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр нь 4.12-д заасны дагуу 4.13-аар 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэхдээ БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд уг орон сууц нь 4 давхар барилгад байгаа тул Сэлэнгэ аймгийн Сайхан сум нь II зэрэглэлд хамаарч К-1.05 байна.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлын итгэлцүүр нь 4.16-д заасны дагуу үнэлэгдэж байгаа орон сууц нь төвийн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон тул 1.0 байна.

Бүсийн итгэлцүүр Сэлэнгэ аймгийн хувьд Хавсралт 4-д зааснаар 0.63 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.17-д заасны дагуу нийт талбайг нэгж үнэлгээ болон орон сууцны талбайн тохируулгын, барилгын өндрийн, байгалийн хүчин зүйлийн, инженерийн шугам сүлжээний холбогдлын, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$$37.78\text{м.кв} * 1107.45\text{мян.₮} * 1.1 * 1.0 * 1.05 * 1.0 * 0.63 = 30,444.48 \text{ мян.₮}$$

Элэгдлийг тооцох:

Элэгдлийн хувийг 4.19-д заасны дагуу тодорхойлоход бидний үнэлж байгаа орон сууцны чанар байдал нь дотор болон гадна талын гэмтэл нь хөнгөн засвар шаардлагатай тул “3-сайн” гэсэн төлөв байдалд хамаарч, хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшинг 15-30%-ийн хооронд байна гэж үзээд 4.20-оор элэгдлийг тухайн барилгын үндсэн хийц бүтээцийн Хавсралт 7-д заасан “нийтийн орон сууц” барилгын хувийн жинг 4.19-өөр тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр 15.65% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)	Элэгдлийн хувь (M=A*Б)
1	Үндсэн хийц, бүтээц	82.80%	15%	12.42%
2	Дээвэр	1.90%	20%	0.38%
3	Сантехник	11.00%	20%	2.20%
4	Цахилгаан	4.30%	15%	0.65%
Элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				15.65%

Орон сууцны барилгын цаашид ашиглах хугацаа (T_{үлд})-г 4.21-д заасны дагуу Хавсралт 6-ийн 1.1-ээс 4-р мөрийн харгалзах “сайн” багана дахь ашиглалтын норматив хугацаа (T_{норм}) 70 жилийг болон 4.20-д тодорхойлсон элэгдлийн хувийг ашиглан тооцоолоход:

$$T_{үлд} = T_{норм} * (1-Э) = 70 * (1-15.65\%) = 59 \text{ жил}$$

Элэгдлийн дүн нь 4.23-д заасны дагуу 4.20-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлоход:

$$30,444.48 \text{ мян.₮} * 15.65\% = 4,763.04 \text{ мян.₮}$$

Орон сууцны барилгын Бодит үнэ цэнийг 4.24-д заасны дагуу 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход:

30,444.48 мян. ₮ - 4,763.04 мян. ₮ = 25,681.44 мян. ₮ байна.

ЖИШЭЭ 3. Үйлдвэрийн барилга

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэгт байрлалтай 1985 онд баригдсан, Угсармал төмөр бетон хавтгаалжин бүтээцтэй, нийт гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар нийт 6016.16 м.кв талбай бүхий баяжуулах үйлдвэрийн зориулалттай 1 давхар барилга, барилгын өндөр 7.0 м, төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугаманд холбогдсон. Барилгын үндсэн хийц бүтээцэд гарсан нүдэнд ил үзэгдэх ан цав, эвдрэл гэмтэл гараагүй ч дээвэр, сантехник, цахилгаанд их засвар хийх шаардлагатай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй барилгын хийц бүтээцийн төрөл нь 4.18-д заасны дагуу “В” ангилалд хамаарч байна. Иймээс нэгж үнэлгээг Хавсралт 2-ын “Үйлдвэрийн барилга” ангилалд байгаа “Төмөрлөгийн үйлдвэр/үндсэн цех”-д харгалзах “В” ангиллын нэгж үнэлгээ 1613.98 мян. ₮-өөр сонгоно.

Барилгыг гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар хэмжсэн тул 4.7-д заасны дагуу барилгын талбайг тогтоохдоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцох тул 4.10-аар 510 мм-ын зузаантай ханатай барилга тул барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 0.94 итгэлцүүрээр бууруулна.

Барилгын өндрийн итгэлцүүр нь 4.11-д заасны дагуу үйлдвэрийн барилгын өндөр 4.5 м байхаар нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон бөгөөд бидний үнэлж буй барилгын өндөр 7.0 м байгаа тул илүү 2.5 м өндрийн 1 м тутмыг 5%-иар өсгөхөд 1.13 гарч байна.

$$1+(7\text{м}-4.5\text{м})\cdot 5\%=1.13$$

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр нь 4.12-д заасны дагуу 4.13-аар 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэхдээ БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд бидний үнэлж байгаа барилгад Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг нь I зэрэглэлд хамаарч К-1.0 байна.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлын итгэлцүүр нь 4.16-д заасны дагуу үнэлэгдэж байгаа барилга нь төвийн дулаан, цэвэр, бохир усны шугаманд холбогдсон тул 1.0 байна.

Бүсийн итгэлцүүр Улаанбаатар хотод Хавсралт 4-д зааснаар 1.0 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.17-д заасны дагуу 4.7-оор тогтоосон нийт талбайг 4.18-ын дагуу Хавсралт 2-оос сонгосон нэгж үнэлгээ болон гадна ханын зузааны, барилгын өндрийн, байгалийн хүчин зүйлийн, инженерийн шугам сүлжээний холбогдлын, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$6016.16\text{м.кв} * 1047.01\text{мян.₮} * 0.94 * 1.13 * 1.0 * 1.0 * 1.0 = 5,921,040.90 \text{ мян.₮}$ байна.

Элэгдлийг тооцох:

Элэгдлийн хувийг 4.19-д заасны дагуу тодорхойлоход бидний үнэлж байгаа барилгын чанар байдал нь дотор болон гадна талын гэмтэл нь хөнгөн засвараас гадна ялангуяа дээврийг хэсэгчлэн, сантехник, цахилгааны монтажийг бүрэн солих шаардлагатай тул “4-дунд” гэсэн төлөв байдалд хамаарч, хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшинг 30-50%-ийн хооронд байна гэж үзээд 4.20-оор элэгдлийг тухайн барилгын үндсэн хийц бүтээцийн Хавсралт 7-д заасан “үйлдвэр агуулах” барилгын хувийн жинг 4.19-оор тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр 39.40% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)	Элэгдлийн хувь (M=A*Б)
1	Үндсэн хийц, бүтээц	80.50%	30%	24.15%
2	Дээвэр	8.50%	50%	4.25%
3	Сантехник	5.30%	100%	5.30%
4	Цахилгаан	5.70%	100%	5.70%
Элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				39.40%

Барилгын цаашид ашиглах хугацаа (T_{үлд})-г 4.21-д заасны дагуу Хавсралт 6-ийн 1.2-оос 16-р мөрийн харгалзах “дунд” багана дахь ашиглалтын норматив хугацаа (T_{норм}) 50 жилийг болон 4.20-д тодорхойлсон элэгдлийн хувийг ашиглан тооцоолоход

$T_{үлд} = T_{норм} * (1 - Э) = 50 * (1 - 39.40\%) = 30 \text{ жил}$ байна.

Элэгдлийн дүн нь 4.23-д заасны дагуу 4.20-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлоход

$5,921,040.90 \text{ мян.₮} * 39.40\% = 2,332,890.11 \text{ мян.₮}$ байна.

Барилгын Бодит үнэ цэнийг 4.23-д заасны дагуу 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход

5,921,040.90мян. ₮ - 2,332,890.11 мян. ₮ = 3,588,150.79 мян. ₮ байна.

ЖИШЭЭ 4. Аж ахуйн аргаар баригдсан барилга

Сүхбаатар аймгийн Дарьганга суманд байрлалтай 1980 онд аж ахуйн аргаар баригдсан, банзан буюу щитэн бүтээцтэй, 260.0 м.кв цэвэр талбай бүхий конторын барилга, өндөр өндөр 2.4 м, энгийн пийшин галлагаатай. Барилгын үндсэн хийц бүтээцэд гарсан нүдэнд ил үзэгдэх ан цав, эвдрэл гэмтэл гараагүй ч их засвар хийгдэх шаардлагатай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй барилгын хийц бүтээцийн төрөл нь 4.18-д заасны дагуу “D” ангилалд хамаарч байна. Иймээс нэгж үнэлгээг Хавсралт 2-ийн “Олон нийтийн барилга” ангилалд байгаа “Захиргаа, аж ахуй, албан контор”-д харгалзах “D” ангиллын нэгж үнэлгээ 948.47 мян. ₮-өөр сонгох бөгөөд 4.14-өөр аж ахуйн аргаар баригдсан барилга тул нэгж хүчин чадлын жишиг үнээгээ 0.75 гэсэн итгэлцүүрээр бууруулж тооцно.

Барилгыг гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар хэмжсэн тул 4.7-д заасны дагуу барилгын талбайг тогтоохдоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцох тул 4.10-аар ханын зузаан 510 мм-ээс бага байгаа учир гадна ханын зузаанаас хамаарах итгэлцүүр 1.0 байна.

Барилгын өндрийн итгэлцүүр нь 4.11-д заасны дагуу олон нийтийн барилгын өндөр 3.3 м байхаар нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон бөгөөд бидний үнэлж буй барилгын өндөр 2.4 м байгаа тул 1.0 байна.

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр нь 4.12-д заасны дагуу 4.13-аар 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэхдээ БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд уг барилга нь 1 давхар барилга тул Сүхбаатар аймгийн Дарьганга сум нь I зэрэглэлд хамаарч К-1.0 байна.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлын итгэлцүүр нь 4.16-д заасны дагуу үнэлэгдэж байгаа барилга нь ердийн пийшин галлагаатай тул 0.75 байна.

Бүсийн итгэлцүүр Сүхбаатар аймгийн хувьд Хавсралт 4-д зааснаар 0.52 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.17-д заасны дагуу 4.7-оор тооцсон нийт талбайг 4.18-ын дагуу Хавсралт 2-оос сонгосон нэгж үнэлгээ болон орон сууцны талбайн тохируулгын, барилгын өндрийн, байгалийн хүчин зүйлийн,

инженерийн шугам сүлжээний холбогдлын, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$$260.0.кв * 948.47\text{мян. ₮} * 0.75 * 1.0 * 1.0 * 1.0 * 0.75 * 0.52 = 72,131.14 \text{ мян. ₮}$$

Элэгдлийг тооцох:

Элэгдлийн хувийг 4.19-д заасны дагуу тодорхойлоход бидний үнэлж байгаа барилгын чанар байдал нь дотор болон гадна талын гэмтэл нь их засвар шаардлагатай тул “5-муу” гэсэн төлөв байдалд хамаарч, хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшинг 50-75%-ийн хооронд байна гэж үзээд 4.20-оор элэгдлийг тухайн барилгын үндсэн хийц бүтээцийн Хавсралт 7-д заасан “захиргаа, аж ахуйн” барилгын хувийн жинг 4.19-өөр тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр 89.30% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)	Элэгдлийн хувь (М=А*Б)
1	Үндсэн хийц, бүтээц	84.20%	100%	84.20%
2	Дээвэр	5.10%	100%	5.10%
3	Сантехник	5.40%	0%	0.00%
4	Цахилгаан	5.30%	0%	0.00%
Элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				89.30%

Конторын барилгын цаашид ашиглах хугацаа (T_{үлд})-г 4.21-д заасны дагуу Хавсралт 6-ийн 1.1-ээс 7-р мөрийн харгалзах “дундаж” багана дахь ашиглалтын норматив хугацаа (T_{норм}) 35 жилийг болон 4.20-д тодорхойлсон элэгдлийн хувийг ашиглан тооцоолоход

$$T_{үлд} = T_{норм} * (1-Э) = 35 * (1-89.30\%) = 4 \text{ жил байна.}$$

Элэгдлийн дүн нь 4.23-д заасны дагуу 4.20-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлоход

$$72,131.14 \text{ мян. ₮} * 89.30\% = 64,413.11 \text{ мян. ₮}$$

Барилгын Бодит үнэ цэнийг 4.24-д заасны дагуу 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход

$$72,131.14 \text{ мян. ₮} - 64,413.11 \text{ мян. ₮} = 7,718.03 \text{ мян. ₮}$$

ЖИШЭЭ 5. Жижиг барилга

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд байрлалтай 1986 онд аж ахуйн аргаар баригдсан, банзан буюу щитэн бүтээцтэй, 58.3 м.кв талбай бүхий 1 давхар, инженерийн шугам сүлжээний холболтгүй, хүйтэн агуулах. Барилгын үндсэн

хийц бүтээцэд гарсан нүдэнд ил үзэгдэх ан цав, эвдрэл гэмтэл гараагүй ч дээврийг бүрэн солих шаардлагатай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй барилгын хийц бүтээцийн төрөл нь “жижиг барилга” ангилалд хамаарч байна. Иймээс нэгж үнэлгээг Хавсралт 2-ийн “жижиг барилга” ангилалд байгаа “банзан буюу бамбайн барилга”-д харгалзах нэгж үнэлгээ 278.83 мян. ₮-өөр сонгоно.

Барилгыг гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар хэмжсэн тул 4.10-д заасны дагуу барилгын талбайг тогтоохдоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцох тул Хавсралт 2-ын “жижиг барилга” ангиллаар нэгж талбайн жишиг үнийг сонгосон учир ханын зузаанаас хамаарах итгэлцүүрийг хэрэглэхгүй.

Барилгын өндрийн итгэлцүүр нь 4.11-д заасны дагуу олон нийтийн барилгын өндөр 3.3 м байхаар нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон бөгөөд бидний үнэлж буй барилгын өндөр 3.0 м байгаа тул 1.0 байна.

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр нь 4.12-д заасны дагуу 4.13-аар 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэхдээ БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд уг барилга нь 1 давхар тул Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум нь I зэрэглэлд хамаарч К-1.0 байна.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлын итгэлцүүр нь 4.16-д заасны дагуу үнэлэгдэж байгаа барилга нь инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй тул 0.75 байна.

Бүсийн итгэлцүүрийг уг барилга нь 4.15-аар нэгж хүчин чадлын үнэлгээг “жижиг барилга” ангиллаар тооцож байгаа тул хэрэглэхгүй.

Бүрэн орлуулах өртгийг 4.17-д заасны дагуу 4.7-д зааснаар тогтоосон нийт талбайг 4.18-ын дагуу Хавсралт 2-оос сонгосон нэгж үнэлгээ болон барилгын өндрийн, байгалийн хүчин зүйлийн, инженерийн шугам сүлжээний холбогдлын итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$58.3.кв * 278.83\text{мян. ₮} * 1.0 * 1.0 * 0.75 = 12,191.84 \text{ мян. ₮}$ байна.

Элэгдлийг тооцох:

а) 4.20-д заасны дагуу үнэлж буй барилгын үндсэн хийц, элементэд харгалзах хувийн жин(A_1-A_4)-г Хавсралт 7-А хэсэг дэх “агуулах” барилгын үндсэн хийц бүтээцийн элементээрх задаргаа хүснэгтээс сонгоход үндсэн хийц бүтээц 83.7%, агуулахын барилга нь халаалтгүй тул сантехникийн өртөгт эзлэх хувийн жин 1.8%-ийг үндсэн хийц бүтээцийн хувийн жин дээр нэмбэл 85.50% болох бөгөөд дээвэр 12.7%, цахилгаан 1.8% байна.

б) Барилгын үндсэн хийц, бүтээцийн элемент бүрийн элэгдлийн түвшинг 4.19-д заасан түвшин(Б₁-Б₄)-гээр үнэлэхэд үндсэн хийц бүтээц нь их засвар хийх шаардлагатай байгаа тул 50%, дээврийг бүрэн солих шаардлагатай тул 75%, цахилгааны тоноглол/гэрэлтүүлэг, розетка, унтраалга гэх мэт/-ыг солих шаардлагатай тул 30%-ийн тус тус түвшинд байна гэж үзсэн.

в) Барилгын үндсэн хийц бүтээцийн хувийн жин (А)-г Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин (Б)-р үржүүлээд, гарсан хувийг нэмж Элэгдлийн хувийг тооцоолоход 52.82% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)%	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)%	Элэгдлийн хувь (М=А*Б)%
1	Үндсэн хийц, бүтээц	85.50%	50%	42.75%
2	Дээвэр	12.70%	75%	9.53%
3	Сантехник	-	-	-
4	Цахилгаан	1.8%	30%	0.54%
Биет элэгдлийн хувь (M₁+ M₂+ M₃+ M₄)				52.82%

Дээрх Элэгдлийн хувь, Хавсралт 6-ийн 1.1-ээс 7-р мөрийн харгалзах “дундаж” багана дахь ашиглалтын норматив хугацаа (Т_{норм}) 20 жилийг 4.21-д заасан томъёонд орлуулан цаашид ашиглах үлдэх нас(Т_{үлд})-ыг тооцоолоход
 $T_{\text{үлд}} = T_{\text{норм}} * (1 - \text{Э}) = 20 * (1 - 52.82\%) = 9 \text{ жил байна.}$

4.23-д заасны дагуу Элэгдлийн дүнг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгийг 4.20-д тооцоолсон элэгдлийн хувиар үржүүлж тодорхойлоход 12,191.84 мян. ₮ * 52.82% = 6,439.12 мян. ₮ байна.

4.24-д заасны дагуу Барилгын Бодит үнэ цэнийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход 12,191.84 мян. ₮ - 6,439.12 мян. ₮ = 5,752.72. ₮ байна.

ЖИШЭЭ 6. Гадаад дахь конторын барилга

ОХУ улсын Москва хотод байрлалтай 1951 онд баригдсан, төмөр бетон суурьтай, 640 мм-ын зузаантай тоосгон ханатай, төмөр бетон хучилттай нийт гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар нийт 3558.4 м.кв талбай бүхий конторын зориулалттай зоорийн давхраас гадна 2 давхар барилга, барилгын өндөр 3.3 м, төвийн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон. Барилгын үндсэн хийц бүтээцэд гарсан нүдэнд ил үзэгдэх ан цав, эвдрэл гэмтэл гараагүй, урсгал засвар хийх шаардлагатай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй барилгын хийц бүтээцийн төрөл нь 4.18-д заасны дагуу “С” ангилалд хамаарч байна. Иймээс нэгж үнэлгээг Хавсралт 2-ын “Олон нийтийн барилга” ангилалд байгаа “захиргаа, аж ахуй, албан контор”-д харгалзах “С” ангиллын нэгж үнэлгээ 965.17 мян. ₮-өөр сонгоно.

Барилгыг гадна ханын гадна гадаргуу хоорондын зайгаар хэмжсэн тул 4.7-д заасны дагуу барилгын талбайг тогтоохдоо барилгын тэнхлэгээс тэнхлэг хүртэлх нийт талбайгаар тооцох тул 4.10-аар 640 мм-ын зузаантай ханатай барилга тул барилгын нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг 0.92 итгэлцүүрээр бууруулна.

Барилгын өндрийн итгэлцүүр нь 4.11-д заасны дагуу олон нийт, үйлчилгээний барилгын өндөр 3.6 м байхаар нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг тооцсон бөгөөд бидний үнэлж буй барилгын өндөр 3.3 м байгаа тул 1.0 байна.

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр нь 4.12-д заасны дагуу 4.13-аар 2 болон түүнээс дээш давхар барилгад хэрэглэхдээ БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд бидний үнэлж байгаа барилга нь ОХУ-ын Москва хотод байршилтай тул хэрэглэхгүй.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байдлын итгэлцүүр нь 4.16-д заасны дагуу үнэлэгдэж байгаа барилга нь төвийн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон тул 1.0 байна.

Бүсийн итгэлцүүр нь Оросын холбооны улсын Москва хотод Хавсралт 4-д зааснаар, хотын төвөөс зайдуу 5.77 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.17-д заасны дагуу 4.7-д зааснаар тогтоосон нийт талбайг 4.18-ын дагуу Хавсралт 2-оос сонгосон нэгж үнэлгээ болон гадна ханын зузааны, барилгын өндрийн, инженерийн шугам сүлжээний холбогдлын, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$3558.4\text{м.кв} * 965.17\text{мян. ₮} * 0.92 * 1.0 * 1.0 * 5.77 = 18,231,492.39$ мян. ₮ байна.

Элэгдлийг тооцох:

а) 4.20-д заасны дагуу үнэлж буй барилгын үндсэн хийц, элементэд харгалзах хувийн жин(А₁-А₄)-г Хавсралт 7-А хэсэг дэх “захиргаа аж ахуй, албан контор” барилгын үндсэн хийц бүтээцийн элементээрх задаргаа хүснэгтээс сонгоход үндсэн хийц бүтээц 85.5%, дээвэр 5.4%, сантехник 5.0%, цахилгаан 4.1% байна.

б) Барилгын үндсэн хийц, бүтээцийн элемент бүрийн элэгдлийн түвшинг 4.19-д заасан түвшин(Б₁-Б₄)-гээр үнэлэхэд үндсэн хийц бүтээц, сантехник нь их засвар хийх шаардлагатай тул 50%, дээвэр нь бүрэн солих шаардлагатай тул 70%, цахилгаан нь хөнгөн засвар хийгдэх шаардлагатай тул 20%-ийн тус тус түвшинд байна гэж үзсэн.

в) Барилгын үндсэн хийц бүтээцийн хувийн жин (А)-г Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин (Б)-р үржүүлээд, гарсан хувийг нэмж Элэгдлийн хувийг тооцоолоход 49.43% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)%	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)%	Элэгдлийн хувь (M=A*B)%
1	Үндсэн хийц, бүтээц	84.20%	50%	42.10%
2	Дээвэр	5.10%	70%	3.57%
3	Сантехник	5.40%	50%	2.70%
4	Цахилгаан	5.30%	20%	1.06%
Биет элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				49.43%

Дээрх Элэгдлийн хувь, Хавсралт 6-ийн 1.2-оос 13-р мөрийн харгалзах “дундаж” багана дахь ашиглалтын норматив хугацаа (T_{норм}) 60 жилийг 4.21-д заасан томъёонд орлуулан цаашид ашиглах үлдэх нас(T_{үлд})-ыг тооцоолоход

$$T_{\text{үлд}} = T_{\text{норм}} * (1 - \text{Э}) = 60 * (1 - 49.43\%) = 30 \text{ жил байна.}$$

4.23-д заасны дагуу Элэгдлийн дүнг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгийг 4.20-д тооцоолсон элэгдлийн хувиар үржүүлж тодорхойлоход 18,231,492.39 мян. ₮ * 49.43% = 9,011,826.69 мян. ₮ байна.

4.24-д заасны дагуу Барилгын Бодит үнэ цэнийг 4.17-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.23-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход

$$18,231,492.39 \text{ мян. ₮} - 9,011,826.69 \text{ мян. ₮} = 9,219,665.70 \text{ мян. ₮ байна.}$$

В. Гадна инженерийн шугам сүлжээ, зам гүүр, инженерийн байгууламжийн үнэлгээ

- 4.28. Барилгын доторх инженерийн шугам сүлжээний өртөг (барилгаас эхний худаг хүртэл) барилгын өртөгт багтсан байдаг тул зөвхөн гадна инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцэд харгалзах утгыг хавсралтаас авч ашиглана.
- 4.29. Инженерийн дэд бүтэц, байгууламж нь зориулалт, шугам хоолойн тоо, голч, материалын төрөл, сувгийн болон сувагчлалын хийц зэргээрээ Хавсралт 3-ийн ангилалын аль ч төрөлд тохирохгүй тохирохгүй байвал хамгийн ойролцоо хийцтэйд хамааруулж үнэлнэ.
- 4.30. Инженерийн дэд бүтэц, байгууламжийн дахин үнэлгээний үндсэн нэгжийг дараах байдлаар ойлгож, ашиглана.
 - Дангаар суурилагдсан шугам хоолойн хувьд / цэвэр ус, бохир ус, холбоо, цахилгааны шугам гэх мэт / 1 м шугам сүлжээ,
 - Дулааны шугамын хувьд 1 м суваг /сувагт суурилагдсан шугам хоолойн тоо 2,3,5 байж болно/

- Инженерийн шугам сүлжээ нэг туннельд угсрагдсан тохиолдолд 1м туннель /туннельд дулааны хос, цэвэр усны, холбоо, цахилгаан, гэрэлтүүлэг, дохиоллын гэх мэт шугам хоолой багтсан байж болно/
 - Авто зам гүүрийн хувьд 1 км зам, гүүр
 - Усан сан, бохирын цооног, цэвэрлэх байгууламж г.м. багтаамжит байгууламжийн хувьд 1м³ шингэн агуулах байгууламж.
 - Цахилгаан хангамжийн байгууламжийн хувьд 1 ширхэг байгууламжийн гэж тус тус авч үзэж үнэлнэ.
- 4.31. Инженерийн дэд бүтэц, байгууламжийн элэгдлийг барилгын элэгдлийг тооцсон 4.19-4.23-д зааснаар, байгалийн хүчин зүйлийн итгэлцүүрийг 4.12-д зааснаар тус тус хэрэглэнэ.
- 4.32. Инженерийн дэд бүтэц, байгууламжийг төрөл, хийцийг нь харгалзан Хавсралт 3-аас тохирох ангилалын нэгж хүчин чадлын үнэлгээг шугам сүлжээний урт эсвэл багтаамж эсвэл тоогоор, Хавсралт 4-д заасан бүсийн итгэлцүүрээр тус тус үржүүлэн Элэгдлийг хасаж үнэлнэ.
- 4.33. Ус хангамжийн барилга байгууламж болох усан сан нь ихэвчлэн барилга, тоног төхөөрөмж, халаалтын байр, хашаа, харуулын байр, зам талбай зэргээс бүрдэх ба хүчин чадлыг нэгж куб метр-т ноогдох үнэлгээгээр үржүүлж тооцно.
- 4.34. Насос станцын барилгад үнэлгээ хийхдээ аргачлалын “Үйлдвэрийн Барилга”-ын хэсгийг мөрдөнө.
- 4.35. Бохир ус цэвэрлэх байгууламжийн нэгж үнэлгээнд барилга, халаалт салхивч, цэвэр бохир усны шугам, гэрэлтүүлэг, элсний болон лагийн талбай, био цөөрмүүд гэх мэт байгууламжууд багтсан тул багтаамжийн хүчин чадлыг нэгж куб м-т ноогдох үнэлгээгээр үржүүлж тооцно.
- 4.36. Бохирын насос станц нь сендвичэн барилга бөгөөд бохир ус зайлуулах хүчин чадал нь мэдэгдэж байвал 1 ком-д харгалзах утгыг Хавсралт 3-аас авч цогцоор нь үнэлнэ.
- 4.37. Хэрэв томоохон хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж (110, 220 кВ-ийн ЦДАШ болон 35/10кВ, 110/10кВ, 110/35/10кВ, 220/110/35кВ-ийн цахилгааны шугам сүлжээ байгууламж, Ф300мм-ээс дээш хүчин чадалтай дулааны шугам сүлжээ)-ийг үнэлэх шаардлага гарвал хавсралт 3а-д өгөгдсөн “Эрчим хүчний барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэ”-ээс харгалзах утгыг сонгон авна. Үнийн өсөлтийн индекс к-1,08 үржүүлж, элэгдлийн хувь хэмжээг тооцож, байгалийн болон нутаг дэвсгэрийн бүсчлэлийн итгэлцүүрээр уялдуулга хийнэ.

Жишээ 1. Хөвсгөл аймгийн Мөрөн хотод байрлалтай 2009 онд барьж байгуулсан 800х385 хэмжээтэй тоосгон сувагтай дулааны шугамыг үнэлье. Сувагт Ф80мм-ийн голчтой дулааны хос шугам, Ф57мм-ийн голчтой цэвэр ус хангамжийн шугам угсрагдсан. Дулааны сувгийн урт 250м ба дулааны 10 худагтай.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлж буй байгууламжийг сувгийн төрөл, хэмжээ, хоолойн тоо, голч зэргээр нь ангилсны дараа Хавсралт 3-ийн хүснэгтээс харгалзах утгыг авна. Ингээд дулааны шугамын барилгын нэг метр сувгийн нэгж үнэлгээ 790 мян. ₮-ийг сонгоно.

Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүрийг аргачлалын 4.12-д заасны дагуу хэрэглэе. БХБ-ын сайдын 2016 оны 85 дугаар тушаалын хавсралт 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр тооцох төв суурин газрууд”-аас хайх бөгөөд бидний үнэлж байгаа барилга нь Хөвсгөл аймгийн Мөрөнд байрлах тул III зэрэглэлд хамаарч К-1.1 байна.

Бүсийн итгэлцүүр нь Хөвсгөл аймгийн хувьд Хавсралт 4-д зааснаар 0.75 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.10-д заасны дагуу дулааны шугамын сувгийн нийт уртыг нэгж хүчин чадлын үнэлгээ болон байгалийн хүчин зүйлийн, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$$250м * 790мян. ₮ * 1.1 * 0.75 = 162,937.5 мян. ₮ байна.$$

Элэгдлийг тооцох:

Элэгдлийн хувийг 4.12-д заасны дагуу тодорхойлоход бидний үнэлж байгаа байгууламжийн чанар байдал нь сайн байгаа тул “2-маш сайн” гэсэн төлөв байдалд хамаарч, хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшинг 5-15%-ийн хооронд байна гэж үзээд 4.13-аар элэгдлийг тухайн барилгын үндсэн хийц бүтээцийн Хавсралт 7-д заасан “соёлын төв” барилгын хувийн жинг 4.12-оор тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр 25.48% байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)%	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)%	Элэгдлийн хувь (M=A*Б)%
1	Газрын ажил	4%	5%	0.20%
2	Сувгийн ажил / тулгуур	35%	10%	3.50%
3	Шугамын угсралтын ажил	54%	5%	2.70%
4	Хүдгийн ажил	7%	15%	1.05%
Биет элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				7.45%

Байгууламжийн цаашид ашиглах хугацаа (T_{үлд})-г 4.14-д заасны дагуу Хавсралт 6-ийн 2.2-оос 65-р мөрийн харгалзах “сайн” багана дахь ашиглалтын норматив

хугацаа ($T_{норм}$) 40 жилийг болон 4.13-д тодорхойлсон элэгдлийн хувийг ашиглан тооцоолоход

$$T_{үлд} = T_{норм} * (1 - Э) = 40 * (1 - 7.45\%) = 37 \text{ жил байна.}$$

Элэгдлийн дүн нь 4.16-д заасны дагуу 4.13-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.10-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлоход

$$162,937.5 \text{ мян. ₮} * 7.45\% = 12,220.31 \text{ мян. ₮ байна.}$$

Байгууламжийн бодит үнэ цэнийг 4.17-д заасны дагуу 4.10-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.16-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход

$$162,937.5 \text{ мян. ₮} - 12,220.31 \text{ мян. ₮} = 150,717.18 \text{ мян. ₮ байна.}$$

Жишээ 2. Дархан Уул аймгийн Дархан суманд 1979 онд бохир усны $\Phi 255\text{мм}$ -ийн голчтой, 120м урттай вааран шугам, $\Phi 150\text{мм}$ -ийн голчтой, 90м урттай ширмэн шугамыг тус тус барьж байгуулсан.

Бүрэн орлуулах өртгийг тооцох:

Үнэлгээ хийж буй бохир усны шугам сүлжээний хүчин чадал (голч), материалын ангилалд харгалзах утгыг Хавсралт 3-аас авна. Гэвч $\Phi 255\text{мм}$ -ийн вааран хоолойн үнэлгээ байхгүй тул ойролцоо хийц, угсралтын адил технологитойгоор нь $\Phi 300\text{мм}$ -ийн төмөр бетон хоолойгоор орлуулж, нэгж үнэлгээ 200,000.0 мян. ₮ -ийг сонгоно. $\Phi 150\text{мм}$ -ийн ширмэн хоолойн хувь нэгж үнэлгээ 260,000.0 мян. ₮ болно.

Дээрх жишээтэй адил “Байгалийн хүчин зүйлийн нөлөөллийн итгэлцүүр”-ийг хайхад Дархан Уул аймгийн Дархан сум нь аль ч зэрэглэлд хамаарагдахгүй байх тул К-1 гэж авна.

Бүсийн итгэлцүүр нь Дархан сумын хувьд Хавсралт 4-д зааснаар 0.83 байна.

Бүрэн орлуулах өртгийг 4.10-д заасны дагуу 1м шугам хоолойн үнэлгээ болон байгалийн хүчин зүйлийн, бүсийн итгэлцүүрүүдээр үржүүлж тодорхойлоход

$$\text{Вааран шугам: } 120 * 200.0 \text{ мян. ₮} * 0.83 = 19,920.0 \text{ мян. ₮}$$

$$\text{Ширмэн шугам: } 90 * 260.0 \text{ мян. ₮} * 0.83 = 19,422.0 \text{ мян. ₮ байна}$$

$$\text{Нийт: } 39,342.0 \text{ мян. ₮}$$

Элэгдлийг тооцох:

Элэгдлийн хувийг 4.12-д заасны дагуу тодорхойлоход бидний үнэлж байгаа бохирын шугамын уулзвар хэсгийг солих, засвар хийх шаардлагатай болсон тул “4-Дунд” гэсэн төлөв байдалд хамаарч, хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшинг 30-50 %-ийн хооронд байна гэж үзэв.

4.13-аар элэгдлийг Хавсралт 7-д заасны дагуу шугамын бүтээц, элементийн хувийн жинг 4.12-оор тодорхойлсон хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшингээр үржүүлэн, жигнэсэн элэгдлийн нийлбэрээр тооцоход 30.5 % байна.

№	Барилгын үндсэн хийц, бүтээцийн нэр	Барилгын Өртөгт эзлэх хувийн жин (А)%	Хийц хэсгийн элэгдлийн дундаж түвшин, (Б)%	Элэгдлийн хувь (M=A*Б)%
1	Газрын ажил	33%	30%	9.90%
2	Шугамын угсралтын ажил	62%	30%	18.60%
3	Худгийн ажил	5%	40%	2.00%
Биет элэгдлийн хувь (M ₁ + M ₂ + M ₃ + M ₄)				30.50%

Байгууламжийн цаашид ашиглах хугацаа (T_{үлд})-г 4.14-д заасны дагуу Хавсралт 6-ийн 1.5-ийн 41-р мөрийн харгалзах “дундаж” багана дахь ашиглалтын норматив хугацаа (T_{норм}) 20 жилийг болон 4.13-д тодорхойлсон элэгдлийн хувийг ашиглан тооцоолоход

$$T_{\text{үлд}} = T_{\text{норм}} * (1 - \text{Э}) = 20 * (1 - 30.5\%) = 14 \text{ жил байна.}$$

Элэгдлийн дүн нь 4.16-д заасны дагуу 4.13-д тооцоолсон элэгдлийн хувийг 4.10-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөр үржүүлж тодорхойлоход

$$39,342.0 \text{ мян. ₮} * 30.5\% = 11,999.31 \text{ мян. ₮ байна.}$$

Байгууламжийн бодит үнэ цэнийг 4.17-д заасны дагуу 4.10-д тооцоолсон бүрэн орлуулах өртгөөс 4.16-д тооцсон элэгдлийн дүнг болон Үнэ цэнийн бууралтын дүнг хасаж тодорхойлоход

$$39,342.0 \text{ мян. ₮} - 11,999.31 \text{ мян. ₮} = 27,342.69 \text{ мян. ₮ байна.}$$

Г. Нийтийн эзэмшлийн байгууламжийн үнэлгээ

- 4.38. Нийтийн эзэмшлийн байгууламжийн дахин үнэлгээний үндсэн нэгж нь 1 м.кв, 1 ширхэг, 1 суулгац байна.
- 4.39. Мод суулгацыг Биологийн хөрөнгийн НББОУС-ийн “үндсэн хөрөнгө”-д бүртгэх шалгуурыг хангасан тохиолдолд дахин үнэлж, тайланд тусгана.
- 4.40. Нийтийн эзэмшлийн байгууламжийг Хавсралт 4-ээс тохирох ангилалын нэгж хүчин чадлын үнэлгээг үндсэн нэгжийн тоогоор, Хавсралт 5-д заасан бүсийн итгэлцүүрээр тус тус үржүүлэн Элэгдлийг хасаж үнэлнэ.
- 4.41. Нийтийн эзэмшлийн байгууламжийн хувьд хийц бүтээцэд задлахгүй 4.19-д заасан хувь хэмжээгээр Элэгдлийн хувийг тооцно.

Тав. Дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах

- 5.1. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж, төсөвт байгууллага нь 2017 оны жилийн эцсийн тооллогын дүнд үндэслэн 2018 онд багтаан энэ аргачлалын дагуу үл хөдлөх хөрөнгө /газар, барилга байгууламж/-ийн дахин үнэлгээг хийнэ.
- 5.2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж, төсөвт байгууллага нь 2018 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дүнг бүрэн тусгана.
- 5.3. Дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгахдаа энэхүү аргачлалаар тооцоолсон Элэгдлийн дүнг ашиглахгүй. Санхүүгийн тайлангийн Хуримтлагдсан элэгдлийн дүнг дахин үнэлгээний үр дүн болох Бодит үнэ цэнээс нэмэгдүүлэх эсвэл бууруулан бичилтыг хийнэ.
- 5.4. Дахин үнэлгээний үр дүн Хөрөнгийн цаашид ашиглах хугацаа (Т_{үлд})-р Санхүүгийн тайланд дахин үнэлэгдсэн хөрөнгийн Хуримтлагдсан элэгдлийг бодно.
- 5.5. Үнэ цэнийн бууралтын шалгалтыг УСНББОУС 21-ийн дагуу хийнэ.
- 5.6. Газар эзэмших/ашиглах эрхийг үнэлсэн дүнгээр биет бус хөрөнгөөр бүртгэнэ.

Дт. Газар эзэмших эрх (Биет бус хөрөнгө)

Кт. Бусад өмч

(Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжид)

Дт. Газар эзэмших эрх (Биет бус хөрөнгө)

Кт. Засгийн газрын оруулсан капитал

(Төсөвт байгууллагад)

- 5.7. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн бол уг өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Өмнө дахин үнэлсний үр дүнд бууралт үүсч байсан бөгөөд түүнийг тухайн хугацаанд алдагдлаар бүртгэсэн хөрөнгө нь дараагийн дахин үнэлгээгээр бодит үнэ цэн өссөн тохиолдолд тухайн алдагдлын хэмжээтэй тэнцүү хэмжээний өсөлтийг нь тайлант хугацааны ашгаар хүлээн зөвшөөрч, түүнээс давсан хэсгийг дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэнэ.
Анхны дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол уг бууралтыг тайлант хугацааны алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Мөн өмнө нь дахин үнэлгээний үр дүнд өсөлт үүссэн бөгөөд дараагийн дахин үнэлгээгээр бууралт үүссэн бол өмнөх дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг тэг болтол бууруулж бичих бөгөөд түүнээс давсан дүнг тайлант хугацааны алдагдлаар бүртгэнэ.
Дахин үнэлгээний нэмэгдэл дансыг дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө данснаас хасагдах үед түүнд ногдох нийт дүнгээр нь хуримтлагдсан ашигт шилжүүлэн бичнэ.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний улмаас хөрөнгийн нэмэгдсэн дүнг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 50 (а) хэсэгт заасны дагуу хувь тэнцүүлэн бүртгэнэ.

Дт. Үндсэн хөрөнгө	xxx	
Кт. Хуримтлагдсан элэгдэл		xxx
Кт. Дахин үнэлгээний нэмэгдэл		xxx

Хэрэв үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний улмаас хөрөнгө буурсан бол тус дүнг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” гэдэгт заасны дагуу бүртгэнэ.

Дт. Хуримтлагдсан ашиг	xxx	
Дт. Хуримтлагдсан элэгдэл		xxx
Кт. Үндсэн хөрөнгө		xxx

Дахин үнэлэгдсэн хуримтлагдсан элэгдлийг хувь тэнцүүлэн бүртгэж байгаа тохиолдолд үнэлсэн бүрэн орлуулалтын өртөг нь анхны өртөг болохгүй, үнэлгээнд тооцоолсон хуримтлагдсан элэгдэл нь бүртгэлд тусгах хуримтлагдсан элэгдэл шууд болохгүй юм. Харин үнэлэгдсэн дансны үнэ нь дахин үнэлэгдсэн дүнтэй тэнцүү байх ёстой.

- 5.8. *Барилга байгууламжид их засвар /дээвэр солих, цахилгааны болон сантехникийн иж бүрэн засвар/, тоног төхөөрөмжийн иж бүрэн засвар, шинэчлэл хийсэн тохиолдолд барилга байгууламжийн дансны үнийг Хавсралт 7-д заасан харгалзах хувь хэмжээгээр бууруулан засварын зардлыг нэмж капиталжуулна. (дахин үнэлгээгээр нэмэгдсэн бол)*

Дт. Хуримтлагдсан элэгдэл (капиталжуулах засварын ажлын хувь хэмжээгээр)

Дт. Дахин үнэлгээний нэмэгдэл

Дт. Үндсэн хөрөнгө (Их засварын зардал)

Кт. Үндсэн хөрөнгө (капиталжуулах засварын ажлын хувь хэмжээгээр)

Кт. Мөнгөн хөрөнгө (их засварт зарцуулсан дүн, материал)

Жишээ ... 2017 онд 600 сурагчтай сургуулийн барилгын анхны өртөг 5,000.0 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл нь 2,350.0 сая төгрөг байх үед дээвэрт нь 138.0 сая төгрөгийн их засвар хийсэн бол дээврийн капиталчилсан дүнг бүртгэе.

Бодолт: Хавсралт ... -ийн дагуу дээврийн өртөг нь барилгын нийт үнийн дүнгийн 2.5 хувийг бүрдүүлэх учир дээврийн хуучин өртгийг бууруулж, шинээр капиталчлах дүнг барилгын өртөгт нэмж бүртгэнэ.

Хуучин дээврийн өртгөөр бууруулна:

Дт. Хуримтлагдсан элэгдэл 125,000.0 м.т (5,000.0 с.тх2.5%)

Кт. Үндсэн хөрөнгө 125,000.0 м.т

Хөрөнгийн хуучирсан хэсэг ашиглах боломжгүй болсон учир тэр дүнгээр нь хуримтлагдсан элэгдлийг бууруулах ёстой.

Шинэ дээврийн өртгөөр капиталжуулна:

Дт. Үндсэн хөрөнгө	138,000.0 м.т
Кт. Мөнгө	138,000.0 м.т

Жишээ ... Хүнсний үйлдвэрийн барилгын анхны өртөг 22,000.0 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл 10,800.0 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 2,800.0 сая төгрөг байхад 2017 онд 930,000.0 мянган төгрөгний сантехникийн засвар хийгдсэн бол засварын зардлыг капиталжуулж бүртгэе.

Бодолт: Хавсралт ... -ийн ... дагуу сантехникийн өртөг нь барилгын нийт үнийн дүнгийн 2.8 хувийг бүрдүүлэх учир сантехникийн хуучин өртгийг бууруулж, шинээр капиталчлах дүнг барилгын өртөгт нэмж бүртгэнэ.

Хуучин сантехникийн өртгөөр бууруулна:

Дт. Хуримтлагдсан элэгдэл	619,600.0	(694.4с.т-74.8)
Дт. Дахин үнэлгээний нэмэгдэл	74,800.0	(2,800.0x2.5%)
Кт. Үндсэн хөрөнгө		694,400.0
	(24,800.0x2.8%)	

Хөрөнгийн хуучирсан хэсэг ашиглах боломжгүй болсон учир тэр дүнгээр нь хуримтлагдсан элэгдлийг бууруулах ёстой.

Шинэ сантехникийн өртгөөр капиталжуулна:

Дт. Үндсэн хөрөнгө	930,000.0 м.т
Кт. Мөнгө	930,000.0 м.т

- 5.9. Барилга байгууламжид их засвар /дээвэр солих, цахилгааны болон сантехникийн иж бүрэн засвар/, тоног төхөөрөмжийн иж бүрэн засвар, шинэчлэл хийсэн тохиолдолд барилга байгууламжийн дансны үнийг Хавсралт 7-д заасан харгалзах хувь хэмжээгээр бууруулан засварын зардлыг нэмж капиталжуулна. (дахин үнэлгээгээр буурсан бол)

Зургаа. Дахин үнэлгээний үр дүнг нягтлан шалгах, нэгтгэх

- 6.1. Төрийн болон Орон нутгийн өмчийн аж ахуй нэгж, байгууллагуудын үл хөдлөх хөрөнгө /газар, барилга байгууламж/-ийн дахин үнэлгээг аргачлалын дагуу хийж, Хавсралт 9-д заасан хураангуй тайланг бичиж, ТӨБЗГ-ын хөрөнгийн бүртгэлийн программд нэгтгэн, аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан электрон болон цаасан хэлбэрээр холбогдох байгууллага /ТӨБЗГ/-д хүргүүлнэ.
- 6.2. Дахин үнэлгээний үр дүн нь энэхүү аргачлалаар тодорхойлсон хөрөнгийн бодит үнэ цэнэ, хөрөнгийн цаашид ашиглах хугацаа (Түлд), дахин үнэлгээний хураангуй тайлан байна.
- 6.3. Төрийн болон Орон нутгийн өмчийн аж ахуй нэгж, байгууллага нь дахин үнэлгээний дүнг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд энэ аргачлалын 5.4-5.8-д заасны дагуу тусгана.

- 6.4. Төрийн болон Орон нутгийн өмчийн аж ахуй нэгж, байгууллага нь Дахин үнэлгээний хураангуй тайланг эрх бүхий хөндлөнгийн, хараат бус үнэлгээчнээр нягтлан шалгалт хийлгэсэн байна.
- 6.5. Дахин үнэлгээний хураангуй тайланг эрх бүхий хөндлөнгийн, хараат бус үнэлгээчин нь ҮОУС102 *Шалган магадлалт ба даган мөрдөлт* стандарт, энэ журмаар тодорхойлсон ажлын цар хүрээнд нягтлан шалгаж, Хавсралт 10-д заасан нягтлан шалгалтын тайланг бичиж, тамга тэмдэг дарж баталгаажуулан ТӨБЗГ-т ирүүлнэ.
- 6.6. ҮОУС 101 Ажлын цар хүрээ стандартын 20.4-ийн дагуу Нягтлан шалгалтын цар хүрээг дахин үнэлгээг үнэн зөв гүйцэтгэсэн эсэх, баримталсан аргыг зөв хэрэглэсэн эсэх, ашигласан орц мэдээлэл (суурийн талбайг тэнхлэгээрх талбайд шилжүүлсэн байдал, барилга байгууламжийн элэгдлийг тооцсон байдал, тохируулгын итгэлцүүрүүдийг сонгосон үндэслэл), үнэ цэнийн талаар байгууллагын гаргасан дүгнэлтийг дэмжих/дэмжихгүй байх учир шалтгаан, үнэлгээний өдрийн талаарх мэдээллийн хүрээгээр тодорхойлно.
- 6.7. Дахин үнэлгээний үр дүн, нягтлан шалгалтын үр дүнг ТӨБЗГ тулган баталгаажуулсны дараа нягтлан шалгалтыг хэрэгжүүлсэн хөндлөнгийн, хараат бус үнэлгээчинд хөлсийг төсөвтөө багтаан зохицуулна.
- 6.8. Дахин үнэлгээний үр дүнг нягтлан шалгах Хөндлөнгийн, хараат бус үнэлгээчнийг сургах, зааварчилгаа өгөх, жагсаалт гаргах ажлыг Хөрөнгийн үнэлгээний Мэргэжлийн байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.

Долоо. Аргачлалын хэрэгжилтэнд тавих хяналт

- 7.1. Энэхүү аргачлалын хэрэгжилтэнд Сангийн яамны Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын газар хяналт тавина.
- 7.2. Төрийн болон Орон нутгийн өмчийн аж ахуй нэгж, байгууллагын дахин үнэлгээний дүнг нэгтгэх ажлыг Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газар хариуцна.
- 7.3. Төрийн болон Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгө /газар, барилга байгууламж/-ийн дахин үнэлгээг хийгээгүй, тогтоосон хугацаанд санхүүгийн тайланд тусгаагүй тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 23.1.2, 23.1.3 заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Сангийн сайдын 2018 оны 7 дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалын 2-р хавсралт

А. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ

Барилгын зориулалт	д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадлын хэмжих нэгж	Нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ /мян.төг/				
				Барилга байгууламжийн хийц бүтээцийн ангилал				
				А	В	С	Д	S
				Төмөр бетон арагт бүтээц, тоосго блокон дүүргэгч ханатай, цутгамал бетон хучилттай	Угсармал төмөр бетон бүтээцтэй, угсармал төмөр бетон хана, угсармал төмөр бетон хучилттай	Холимог /бетон бус, зүрхэвчтэй/, даацын тоосго, блокон дүүргэгч ханатай, угсармал болон цутгамал хучилттай	Даацын өрөгт болон модон холимог бүтээцтэй, холимог дүүргэгч болон модон хана, модон болон хөнгөвчилсэн хавтан хучилттай	Хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан /сандвич/ болон хөнгөвчилсэн бүтээцтэй, мөн хана, хучилттай
1	2	3	4	5	6	7	8	9
Нэг.Олон нийтийн барилга	1	Захиргаа, аж ахуй, албан контор /шилэн фасадтай/	1 м.кв	1379.45 1526.61	1169.95 0.00	965.17 0.00	948.47 0.00	818.22 0.00
	2	Соёлын төв /шилэн фасадтай/	1 м.кв	1357.29 1642.41	1460.06 0.00	1223.06 0.00	961.67 0.00	0.00 0.00
	3	Театр	1 м.кв	1265.14	0.00	1282.19	0.00	0.00
	4	Спорт заал	1 м.кв	1203.84	1136.87	1074.30	883.55	851.95
	5	Худалдаа үйлчилгээ, битүү зах	1 м.кв	1258.95	1382.55	1199.00	1264.40	803.80
	6	Нийтийн хоол, зоогийн газар	1 м.кв	1271.54	0.00	1199.00	1042.48	948.63
	7		1 м.кв	1338.96	0.00	1144.50	924.55	926.83

		Ахуй үйлчилгээний төв /шилэн фасадтай/		1613.31	0.00	0.00	0.00	0.00
	8	Сургууль	1 м.кв	1009.25	1463.09	881.35	1087.21	0.00
	9	Цэцэрлэг ясли	1 м.кв	1292.46	1184.14	1187.14	1278.93	0.00
	10	Дотуур байр	1 м.кв	1069.36	1181.69	1097.82	1069.90	0.00
	11	Клиник	1 м.кв	1141.11	1356.27	1275.43	1122.70	0.00
	12	Эрүүл мэндийн төв	1 м.кв	1106.42	0.00	1171.82	1111.69	0.00
	13	Өрхийн эмнэлэг, цагдаа, хорооны цогцолбор	1 м.кв	888.92	916.09	888.92	861.82	0.00
	14	Усан бассейн	1 м.кв	1693.87	0.00	1504.40	0.00	0.00
	15	Банк санхүү /шилэн фасадтай/	1 м.кв	1324.90	0.00	1338.15	882.97	0.00
1514.66				0.00	0.00	0.00	0.00	
	16	Зочид буудал	1 м.кв	1363.22	0.00	1281.84	1068.20	0.00
Хоёр.Орон сууцны барилга	1	Амины орон сууц	1 м.кв	1660.16	0.00	1436.24	1380.94	0.00
	2	Нийтийн орон сууц	1 м.кв	1199.10	1107.45	986.87	0.00	0.00
	3	Бүрэн цутгамал	1 м.кв	1558.81	0.00	0.00	0.00	0.00
Гурав. Үйлдвэрийн барилга	1	Засвар механикийн үйлдвэр	1 м.кв	1047.01	973.46	846.48	0.00	850.20
	2	Авто машины гараж	1 м.кв	0.00	848.96	738.22	627.49	708.50
	3	Хүнд машин механизмийн гараж	1 м.кв	0.00	1131.09	983.56	0.00	1539.41
	4	Хөнгөн үйлдвэр (үндсэн цех)	1 м.кв	1253.67	1038.34	902.91	0.00	0.00
	5	Хэвлэх үйлдвэр (үндсэн цех)	1 м.кв	1406.27	1144.53	995.25	0.00	0.00
	6	Хүнсний үйлдвэр (үндсэн цех)	1 м.кв	1504.20	1228.28	1373.40	0.00	0.00

	7	Барилгын материалын үйлдвэр	1 м.кв	1199.22	1151.15	1306.71	0.00	0.00
	8	Арьс нэхий, ноосны үйлдвэр (Үндсэн цех)	1 м.кв	1155.40	991.82	862.45	0.00	0.00
	9	Тоосгон завод (Үндсэн цех)	1 м.кв	1220.07	1166.47	1060.93	0.00	0.00
	10	Шохойн үйлдвэр	1 тн	0.00	0.00	83.70	0.00	0.00
			1 м.кв	0.00	0.00	1173.39	0.00	0.00
	11	Төмөрлөгийн үйлдвэр (Үндсэн цех)	1 м.кв	1714.34	1613.98	1490.73	0.00	0.00
	12	Бетон эдлэлийн цех (Үндсэн цех)	1 м.кв	0.00	1366.22	1188.01	0.00	0.00
			1 м.куб	0.00	0.00	1540.70	0.00	0.00
13	Биохимийн үйлдвэр (Үндсэн цех)	1 м.кв	0.00	1059.14	921.00	0.00	0.00	
14	Халаалтын тогооны барилга	1 м.кв	1503.15	1366.50	1161.53	1045.38	0.00	
Дөрөв.Хөдөө аж ахуйн барилга	1	Сүүний ферм	1 үнээ	2548.80	0.00	2166.48	1911.60	0.00
		Энгийн ферм	1 үнээ	0.00	0.00	632.20	534.10	0.00
	2	Гахайн байр	1 мэгж	896.72	0.00	0.00	0.00	0.00
			1 м.кв	1000.96	0.00	850.81	750.72	0.00
	3	Тэжээлийн агуулах	1 м.кв	723.95	0.00	615.35	542.96	0.00
			1 тн	0.00	812.48	0.00	0.00	0.00
	4	Ногооны агуулах	1 м.кв	0.00	1149.46	919.57	862.09	0.00
			1 тн	0.00	1028.09	0.00	0.00	0.00
5	Зоорь	1 м.куб	0.00	741.75	593.40	556.31	0.00	
Тав.Тусгай барилга	д/д	Нэр төрөл			Хүчин чадал		Нийт хүч чадлын жишиг үнэлгээ /сая төг/	
	1	Цементийн агуулах			100 тн		29.43	

		Цементийн агуулах	1000 тн	92.65
2	Зуурмагийн узел /тоног төхөөрөмжийн хамт/		1000 өдөр/м.куб	436.00
	Зуурмагийн узел /тоног төхөөрөмжийн хамт/		3000 өдөр/м.куб	2004.51
3	Тавцан /ачиж буулгах/	Угсармал бетон хавтан	1 м.кв	124.42
		Цутгамал бетон	1 м.кв	154.38
		Металл тулгууртай угсармал бетон хавтан	1 м.кв	308.31
4	Үр тариа хадгалах сав /метал силос, элеватор/	180 тн - 300 тн	1 м.куб	152.60
	Үр тариа хадгалах сав /метал силос, элеватор/	300 тн - 1000 тн	1 м.куб	130.80
5	Резервуар	ил	1 м.куб	271.63
		далд	1 м.куб	475.02
6	Далан	шороон хучилттай	1 м.кв	168.30
		бетон хучилттай	1 у.м	212.11
7	Шатахуун түгээх станц	түгээгч, үйлчилгээний байртай	1 м.кв	1096.11
8	Гэрэлтүүлгийн цамхаг/матч/	Бетон суурьтай, металл	1 ширхэг	10015.57

**Б. ЖИЖИГ БАРИЛГУУДЫН
НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ**

д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадлын хэмжих нэгж	Нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ /мян.төг/
1	Банзан буюу бамбайн барилга	1 м.кв	278.83
2	Хөөсөнцөр дулаалгатай 1 талаас нь төмөрлөсөн хавтан /сэндвич/ барилга	1 м.кв	462.63
3	Дүнзэн барилга	1 м.кв	417.55
4	Шургааган байшин	1 м.кв	209.12
5	Чулуун байшин	1 м.кв	209.12
6	Мод, тоосго, блокон холимог ханатай барилга	1 м.кв	428.40
7	Тоосго, бетон агуулах	1 м.кв	260.10
8	Мод, чулуун агуулах	1 м.кв	120.36
9	Сүрлэн байшин	1 м.кв	269.51
10	Саравч /агуулах/	1 м.кв	185,00
11	Хүлэмж /энгийн/	1 м.кв	14.92
12	Хүлэмж /үйлдвэрийн/	1 м.кв	59.69

ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ҮНЭЛГЭЭ

1. Гадна дулааны сүлжээ, барилга байгууламж

Сувгийн төрөл	Сувгийн хэмжээ	Хоолойн материал	Хоолойн хэмжээ	1м-ийн үнэлгээ /сая. төг/
Тоосго	800x385	Ган	2 Ф89, Ф57	0.79
	1200x460		2Ф89, 2Ф57, Ф32	1.15
	1600x460		Ф108, Ф108, Ф108, Ф89, Ф57	1.19
	1800x610		Ф108, Ф108, Ф108, Ф89, Ф57	1.51
цутгамал	800x385	Ган	Ф89, Ф89, Ф32	0.89
	1200x460		Ф89, Ф89, Ф57, Ф57, Ф32	1.26
	1600x460		Ф108, Ф108, Ф108, Ф89, Ф57	1.29
	1800x610		Ф108, Ф108, Ф108, Ф89, Ф57	1.54
угсармал	900x450	Ган	Ф89, ф89, ф32	0.68
	1200x600		Ф89, ф89, ф57, ф57, ф32,	1.26
	1500x600		Ф219, Ф219, Ф159	2.17
	2100x600		Ф325, Ф325, Ф219	2.85
	2100x600		Ф377, Ф377	2.33
	2100x600		Ф630, Ф630	2.61
Нэвтрэх хонгил /2.4-ийн өргөнтэй, 3м-ийн өндөртэй хонгил/			Цутгамал т/б нэвтрэх сувагт байрлуулсан Ф40-250 хүртэлх дулааны, Ф50-150мм хүртэлх цэвэр усны, холбоо, цахилгаан, автомат дохиолол бүхий хонгилын иж бүрэн систем	7.17
Дулаан дамжуулах төвийн 1 иж бүрдлийн төсөвт өртөг /ДДТ иж бүрэн/			Хүчин чадал	1 ком-ын үнэлгээ /сая.төг/
УДДТөвийн барилга /Халаалт, салхивч, дулаан механик, цэвэр бохир ус, гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж бүхий/			7гкал/цаг	548.22
УДДТөвийн барилга/Халаалт, салхивч, дулаан механик, цэвэр ус, бохир ус, гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж бүхий/			1-5 гкал/цаг	304.4

2. Ариутгах татуургын сүлжээ, барилга байгууламж

Бохирын шугам	Хоолойн төрөл	Хоолойн хэмжээ	1м-ийн үнэлгээ /сая. төг/
Хуванцар	Полиэтелин хуниаст гадаргуутай /SN8/	Ф100	0.17
		Ф150	0.31
		Ф300	0.33
		Ф800	0.44
Ширэм	Зөөлөн ширэм /Ductile iron/	Ф100	0.23
		Ф150	0.26
		Ф300	0.33
		Ф800	0.84
Төмөр бетон	Бурзонт төмөр бетон /6м урттай/	Ф300	0.20
		Ф450	0.25
		Ф500	0.35
		Ф800	0.43
Бохирын цооног	Зориулалт	Хүчин чадал	1 м3-ийн үнэлгээ /сая.төг/
Цутгамал төмөр бетон	Ахуйн /Үйлдвэрийн	(30м3-40м3)	1.66
Цэвэрлэх байгууламж /ахуйн хэрэглээний/		Хүчин чадал	1 м3-ийн үнэлгээ /сая.төг/
		Барилга, халаалт салхивч, цэвэр бохир ус, гэрэлтүүлэг, элсний талбай, лагийн талбай, биоцөөрөм, эрлифт, жигдрүүлэх сан, бусад шугам сүлжээ	12.66
Цэвэрлэх байгууламж /үйлдвэрийн/		Сараалжийн барилга, бохирын шугам, халаалт салхивч, технологийн хэсэг, цөөрмийн далан, биоцөөрмүүд	8.69
Бохир усны насос станц		Цутгамал төмөр бетон суурь бүхий сендвичэн барилга /халаалт, цэвэр, бохир ус, гэрэлтүүлэг, технологийн хэсгийн хамт/	1.89

3. Ус хангамжийн сүлжээ, барилга байгууламж

№	Цэвэр усны шугам	Хоолойн төрөл	Хоолойн хэмжээ	1м-ийн үнэлгээ /сая. төг/
1	Хуванцар	HDPE PE100 SDR11	Ф110	0.20
			Ф200	0.24
			Ф250	0.25
			Ф355	0.41
			Ф400	0.50
			Ф450	0.56
			Ф500	0.83
			Ф630	1.05
			Ф800	1.90
2	Ган	Шулуун оёдолтой	Ф80	0.16
			Ф150	0.17
			Ф325	0.49
			Ф600	0.66
			Ф800	1.26
3	Усан сан	Цутгамал төмөр бетон	Хүчин чадал	1 м3-ийн үнэлгээ /сая.төг/
			Усан сан, халаалтын байр, манаачийн бутка, халаалт, салхивч, гэрэлтүүлэг, технологийн хэсэг /500-1500м3/	0.50

4. Холбооны шугам сүлжээ

№	Ангилал	Хүчин чадал	1м-ийн үнэлгээ /сая. төг/
1	Гол сувагчлал, угсармал төмөр бетон худаг /ф-110 мм/	(2+0) сувагчлалтай, L4Т төрлийн /жигиг/	0.10
		(4+0) сувагчлалтай, L5Т төрлийн /дунд/	0.13
		(6+0) сувагчлалтай, M1 төрлийн /том/	0.18
		(9+0) сувагчлалтай, M1 төрлийн /том/	0.23
		(0+2) сувагчлалтай, L4Т төрлийн /жигиг/	0.054

	Салбар сувагчлал /ф-63 мм/, угсармал төмөр бетон худаг	(0+4) сувагчлалтай, L5T төрлийн /дунд/	0.06
2	Бэлэн сувагчлалаар кабель суурилуулах	Шилэн кабель FO8-FO12	0.004
		Шилэн кабель FO-12	0.0045
		Шилэн кабель FO-24	0.0056
		Шилэн кабель FO-48	0.009
		Шилэн кабель FO-96	0.011
		Шилэн кабель FO-144	0.014
		Физик кабель 10 хос	0.006
		Физик кабель 20 хос	0.007
		Физик кабель 30 хос	0.009
		Физик кабель 50 хос	0.012
		Физик кабель 100 хос	0.02
		Физик кабель 200 хос	0.035
3	Агаарын баганат шугам байгуулж, кабель татах	Шилэн кабель FO8, FO12, FO24, FO48	0.01
		Шилэн кабель FO-12	0.0106
		Шилэн кабель FO-24	0.011
		Шилэн кабель FO-48	0.012
		Шилэн кабель FO-96	0.015
		Физик кабель 10 хос-30 хос хүртэл	0.011
		Физик кабель 20 хос	0.012
		Физик кабель 30 хос	0.013
		Физик кабель 50 хос	0.014
		Физик кабель 100 хос	0.018
4	Газрын кабель суурилуулах	Шилэн кабель FO-12, FO24, FO48	0.022
		Шилэн кабель FO-24	0.023
		Шилэн кабель FO-48	0.024
		Шилэн кабель FO-96	0.027
		Физик кабель 50 хос	0.028
		Физик кабель 100 хос	0.030
5	Ангилал	Хүчин чадал	1 ком-ын үнэлгээ /сая.төг/
	Хуваарилах шүүгээ	Физик кабелийн	2.98
		Шилэн кабелийн	4.83

5.Цахилгааны шугам сүлжээ, барилга байгууламж

Цахилгааны барилга байгууламж, дамжуулах шугамын нэр	Төрөл	Хүчин чадал	1м-ийн үнэлгээ /сая. төг/
А. Цахилгаан дамжуулах шугам	кабель /Хөнгөнцагаан голтой/	0.4 кВ 3х35+1х16 мм ²	0.041
		0.4 кВ 3х70+1х35 мм ²	0.047
		0.4 кВ 3х95+1х50 мм ²	0.055
		0.4 кВ 3х185+1х95 мм ²	0.072
		0.4 кВ 3х240+1х120 мм ²	0.076
		10 кВ 3х35 мм ²	0.051
		10 кВ 3х70 мм ²	0.062
		10 кВ 3х95 мм ²	0.066
		10 кВ 3х185 мм ²	0.079
		10 кВ 3х240 мм ²	0.083
	Агаарын шугам	0.4 кВ СИП утастай	0.032
		10 кВ АС утастай	0.028
		15 кВ АС утастай	0.029
		35 кВ АС утастай110 кВ	0.046
Б. Цахилгааны барилга байгууламж	Агаарын дэд өртөө	10 /0.4 кВ, 100кВа	24.06
		10 /0.4 кВ, 160кВа	26.18
		10/0.4 кВ, 250 кВа	28.19
		10/0.4 кВ, 400 кВа	32.28
		35/0.4кВ, 400 кВа	102.39
	Хаалттай дэд өртөө /Ачаалал таслагчтай/	10 /0.4 кВ, 250кВа	251.11
		10 /0.4 кВ, 400кВа	259.27
		10/0.4 кВ, 630 кВа	269.98
		10/0.4 кВ, 800 кВа	245.49
		10/0.4кВ, 1000 кВа	310.15
	Хаалттай дэд өртөө /Вакуум таслууртай/	10 /0.4 кВ, 250кВа	360.29
		10 /0.4 кВ, 400кВа	368.56
		10/0.4 кВ, 630 кВа	384.46
		10/0.4 кВ, 800 кВа	348.52
		10/0.4кВ, 1000 кВа	417.85
	10 /0.4 кВ, 160кВа	31.05	

	Иж бүрэн дэд өртөө /КТПН/	10 /0.4 кВ, 400кВа	40.7
		10/0.4 кВ, 630 кВа	46.0
	Хаалттай хувиарлах байгууламж	16 ячейктай	594.75
		20 ячейктай	826.87

6. Гүүр, авто замын барилга байгууламж

А. Гүүрийн барилга байгууламж	Гүүрийн төрөл	Гүүрийн өргөн	1 м-ийн төсөвт өртөг /сая. Төг/
	Төмөр бетон	6м	15.8
	Модон	6м	6.3

Б. Авто замын барилга байгууламж	Хучилтын төрөл	Замын өргөн	1 км-ийн төсөвт өртөг /сая. Төг/
	Асфальто 5см	6м	571.7
	Асфальто 7см	Борооны ус зайлуулах шугам, явган хүний замын хамт	857.5
	Хайрга	6м	518.2
	Сайжруулсан шороо	6м	261.4

7. Үерийн хамгаалалтын барилга байгууламж

А. Үерийн далан суваг	Төрөл	Сувгийн өргөн	1 м-ийн төсөвт өртөг /сая. Төг/
	Ул болон налууд төмөр бетон	6-9 м өргөн	1.1
	Налууд төмөр бетон доторлогоотой		

Б. Ус зайлуулах суваг	Төрөл	Сувгийн өргөн	1 м-ийн төсөвт өртөг /сая. Төг/
	Чулуун доторлогоотой	1м өргөн, 1 м гүн	0.36

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ҮНЭЛГЭЭГ НУТАГ ДЭВСГЭРИЙН БҮСЧЛЭЛЭЭР
ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР****А.АЙМАГ, СУМ**

№	Улс, аймаг, хот	Аймгийн төв
1	Улаанбаатар хот	1
2	Архангай	0.68
3	Баянхонгор	0.82
4	Булган	0.66
5	Говь-Алтай	0.73
6	Дархан-Уул	0.83
7	Дорноговь	0.69
8	Дорнод	0.74
9	Дундговь	0.67
10	Завхан	0.69
11	Орхон	0.68
12	Өвөрхангай	0.66
13	Өмнөговь	0.65
14	Сүхбаатар	0.52
15	Сэлэнгэ	0.63
16	Төв	0.64
17	Увс	0.74
18	Хөвсгөл	0.75
19	Хэнтий	0.63
20	Ховд	0.73
21	Баян-Өлгий	0.69
22	Говьсүмбэр	0.67
23	Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум	0.69

**Б. ГАДААД ДАХЬ ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУД БАЙРЛАХ УЛС
ОРНООР**

№	Улс	Хот	Хотын төвд	Хотоос зайдуу
1	АБНЕУ	Каир	1.48	0.98
2	Австрали	Канберра	10.51	7.89
3	Австри	Вена	20.81	10.41
4	АНУ	Вашингтон	11.88	6.46
5	АНУ	Нью-Йорк	29.97	18.73
6	АНУ	Сан Франциско	22.48	18.54
7	Бельги	Брюссель	7.91	6.24
8	БНАСАУ	Пхеньян	-	-
9	БНКазакстан Улс	Алмата	2.47	1.81
10	БНКазакстан Улс	Астана	2.66	1.86
11	БНКиризи Улс	Бишкек	1.57	1.22
12	БНТУ	Анкара	2.02	1.21
13	БНТУлс	Истанбул	6.05	2.42
14	БНХАУ	Эрэн	41.21	19.23
15	Болгар	Софи	8.23	2.74
16	Бразил	Бразил	3.57	2.20
17	Вьетнам	Ханой	3.39	2.09
18	Герман	Берлин	3.40	2.34
19	ИБУИВУ	Лондон	5.32	3.38
20	Индонези	Жакарта	9.17	2.29
21	Итали	Ром	12.49	8.33
22	Канад	Оттава	47.14	23.57
23	Куба	Гавана	6.22	2.49
24	Кувейт	Ал-Зара	20.81	8.32
25	Лаос	Вьентьян	12.45	6.12
26	ОХУ	Кызыль	1.74	0.52
27	ОХУ	Москва	5.77	5.77
28	ОХУ	Улаан-Үүд	2.09	1.39
29	ОХУ	Эрхүү	14.05	5.62
30	Польш	Варшав	1.87	1.56
31	Сингапур	Сингапур	1.97	1.65
32	Солонгос	Сөүл	1.69	1.41
33	Тайланд	Бангкок	7.32	3.90
34	Унгар	Будапешт	42.14	21.07
35	Франц	Парис	66.81	42.12
36	Хонконг	Хонконг	32.64	19.58
37	Хятад	Бээжин	9.84	5.46
38	Хятад	Хайлари	6.60	3.96

ТӨСӨЛ

39	Хятад	Хөххот	24.98	17.07
40	Чех	Прага	12.23	6.52
41	Швед	Стокгольм	20.27	15.20
42	Швейцарь	Женев	26.11	17.41
43	Энэтхэг	Дели	6.95	3.87
44	Япон	Осака	7.95	6.36
45	Япон	Токио	25.45	11.13

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ҮНЭЛГЭЭ

д/д	Нэр төрөл	Хийцийн төрөл	Хүчин чадлын хэмжих нэгж	Нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ /мян.төг/
1	Хашаа, хашлага, хайс	Угсармал төмөр бетон хашаа	1 м.кв	46.41
2		Төмөр сараалжин /тоосго, бетон суурьтай/ хашаа	1 м.кв	41.62
3		Төмөр/нимгэн төмөр/ хашаа	1 м.кв	11.02
4		Тоосго, блокон хашаа	1 м.кв	45.78
5		Торон хашаа	1 м.кв	8.32
6		Модон хашаа	1 м.кв	25.42
7		Модон сараалжин хайс, хашлага	1 м.кв	6.94
8		Өргөст торон хашлага	1 м.кв	4.00
9	Авто машины болон явган зам, талбай	Бетон хучилттай автомашины зогсоол	1 м.кв	69.36
10		Асфальтобетон хучилттай автомашины зогсоол	1 м.кв	63.55
11		Сайжруулсан шороон хучилттай автомашины зогсоол	1 м.кв	9.00
12		Бетон хучилттай явган зам, талбай	1 м.кв	32.95
13		Шигтгэмэл хавтан хучилттай явган зам, талбай	1 м.кв	49.47**
14	Ногоон байгууламж, тохижилт	Зүлэгжүүлсэн талбай	1 м.кв	11.93
15		Биеийн тамирын талбай	1 м.кв	34.68
16		Тоглоомын талбай	1 м.кв	86.70
17		Шилмүүст мод	1 суулгац	39.07
18		Навчит мод	1 суулгац	7.45
19		Бут, сөөг	1 суулгац	5.10
20		Сүүдрэвч	1 м.кв	80.00
20		Гэрэлтүүлэг /металл шонтой/	1 ширхэг	459.00
21		Гэрэлтүүлэг /бетон шонтой/	1 ширхэг	69.36
22		Бие засах газар/жорлон/	1 хүн	471.00
23	Нийтийн бие засах газар	1 м.кв	750.00	

** гадаад улс оронд тухайн орны зах зээлийн жишиг мэдээлэлд тулгуурлан өөрчилж болно.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНД БАРИМТЛАХ ҮЛ ХӨДЛӨХ БА ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН НОРМАТИВ ХУГАЦАА

№	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жил	
		Сайн	Дундаж
Нэг. Барилга байгууламж			
1.1. Орон сууцны болон оффисийн зориулалттай барилга			
1	Төмөр бетон суурь, араг бүтээц, цутгамал ханатай, оффисийн болон орон сууцны барилга	90	80
2	Төмөр бетон суурь, араг бүтээц, блокон болон тоосгон ханатай оффисийн болон орон сууцны барилга	70	60
3	Төмөр бетон суурь, төмөр араг бүтээц, шилэн фасадтай барилга	70	65
4	Угсармал хавтгалжин барилга	70	60
5	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, угсармал болон бетон хучилттай барилга	60	50
6	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, модон хучилттай барилга	50	45
7	Холимог бүтэцтэй болон дүнзэн байшин	40	35
8	Төмөр бетон суурьтай, сендвичэн оффисын барилга	35	30
9	Зуслангийн модон байшин, угсармал болон бусад хөнгөвчилсөн хийцийн модон байшин	30	20
1.2. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, олон нийтийн зориулалттай барилга			
10	Төмөр бетон суурь, карказтай, блокон болон тоосгон ханатай үйлдвэрлэл, үйлчилгээ, олон нийтийн барилга	70	60
11	Төмөр бетон суурьтай блокон болон тоосгон өрлөгтэй үйлдвэрлэл, үйлчилгээний барилга	60	55
12	Төмөр бетон суурьтай, төмөр араг бүтээц, сендвичэн ханатай үйлдвэрлэл, үйлчилгээний барилга	50	30
13	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, угсармал болон бетон хучилттай барилга	60	50
14	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, модон хучилттай барилга	50	45
15	Төмөр бетон буюу цутгамал суурьтай тоосго, блокон агуулах, гаражийн зориулалттай барилга	60	50
16	Том хавтгаалжин ханатай үйлдвэрийн барилга	60	50
17	Бетон суурьтай сендвичэн агуулах, гаражийн зориулалттай барилга	40	30
18	Холимог хийцтэй агуулах, гаражийн зориулалттай барилга	45	40
19	Банз, шургааг, наамал модон, шитэн ханатай байшин	40	30
20	Бетон суурьтай, тоосго, чулуу, блокон ханатай худаг, уурын зуухны зориулалттай барилга	55	45
1.3. Нийтийн эзэмшлийн талбайн байгууламж			
21	Сандал, сүүдрэвч, хогийн сав		10
22	Автобус, троллейбусны буудал		10
23	Өнгөт хавтан, чулуун талбай, явган хүний зам		25
24	Явган хайс, хашлага		8
25	Тоглоомын болон биеийн тамирын талбай		10
26	Угсармал, цутгамал төмөр бетон далан, үерийн далан		60

ТӨСӨЛ

27	Гадна реклам чимэглэл, тэмдэг		5
28	Гадна гэрэлтүүлгийн төхөөрөмж		10
1.4. Улс, орон нутгийн чанартай зам, замын байгууламж			
29	Асфальт бетон хучилттай зам		13
30	Цемент бетон хучилттай зам		25
31	Хөнгөвчилсөн хучилттай зам		8
32	Хайрган зам		10
33	Сайжруулсан хөрсөн зам		4
34	Төмөр бетон гүүр		75
35	Модон гүүр		20
1.5. Бусад байгууламж			
36	Төмөр, төмөр бетон тулгууртай 0,4-20 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		30
37	Модон тулгууртай 0,4-20 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		15
38	Төмөр, төмөр бетон тулгууртай 35-220, 330 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		50
39	Модон тулгууртай 35-220, 330 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		30
40	Цахилгаан дамжуулах кабель шугамын байгууламж /ЦДКаШ/		40
41	Цэвэр ус татах, бохир ус зайлуулах байгууламж		20
42	Цахилгаан станц болон уурын зуухны яндан /чулуун, төмөр бетон/		50
43	Цахилгаан станц болон уурын зуухны яндан /төмөр/		25
44	Бетон зуурмагийн узель, бетон цутгалтын силос, нүүрсний бункер		30
45	Үр тариа хадгалах силос		30
46	Зоорь		20
47	Модон араг бүтээцтэй, плёнкон хучилттай, энгийн зориулалттай хүлэмж		8
48	Модон болон төмөр араг бүтээцтэй, плёнкон хучилттай үйлдвэрийн аргаар баригдсан хүлэмж		25
49	Төмөр араг бүтээцтэй, шилэн болон плёнкон хучилттай хүлэмж		30
50	Төмөр бетон суурьтай, төмөр болон цутгамал хашаа		30
51	Хад чулуун хашаа болон гинжин, төмөр хашаа		25
52	Модон хашаа		15
53	Малын хашаа, хороо		15
54	Худаг, ус хангамжийн цооног		20
55	Худаг, ус хангамжийн цооног, цамхаг /төмөр/		20
56	Худаг, ус хангамжийн цооног, цамхаг /тоосго/		40
57	Услалтын систем /байгууламжаар/		25
58	Шатахуун түгээх станцын түгээгүүр, бусад байгууламж		20
59	Газрын тосны хайгуул, олборлолтын талбайд ашигладаг нүүдлийн сууц		5
60	Гэр		15
61	Контейнер /төмөр чингэлэг/		20
Хоёр. Машин, тоног төхөөрөмж		Сайн	Дундаж
2.1. Барилгын материалын үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж			
62	Дугуй болон хонгил зуух, тээрэм, хайлах, цутгах, төмөр эдлэл хийх тоног төхөөрөмж, хатаагуур, түүний тоноглол	15	10

63	Эргэх зуух, металл боловсруулах суурь машин, хайлах, цутгах, тоосгоны шавар боловсруулах болон механизмын засварын үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж, гидро карьер, цахилгаан зуух, керамик эдлэхүүний бүх төрлийн тунгаагч, арматур сунгах, таслах, нугалах болон эрдэс хөвөн эдлэхүүний тоног төхөөрөмж	27	25
64	Бетон эдлэл хэвлэх болон зуурмагийн үзелийн бүх төхөөрөмж, бетон зуурагч, карьерын тэжээгүүр, бутлах, ялгах, шигших тоног төхөөрөмж, тоосго, хавтанцар үйлдвэрлэх шахуурга	10	8
65	Доргиурт ширээ	6	4
66	Угааж цэвэрлэх, тослох, цэнэглэх, задалж угсрах зэрэг зориулалтын тоног төхөөрөмж	7	5
2.2. Эрчим хүч, уул уурхайн үйлдвэрийн тоног төхөөрөмж			
67	Дулааны шугам, далд уурхайн төмөр, төмөр бетон бэхэлгээ, уурхайн бусад байгууламж	40	35
68	Бүх төрлийн зуух, турбин, 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, дэд өртөө, 5-аас дээш шоо метр багтаамжийн шанагатай экскаватор, илчит тэрэг, цахилгаан зүтгүүр	20	15
69	Минутад 500 хүртэл болон 501-1000 эргэх хурдтай дизель генератор, ермийн машин, бульдозер, автогрейдер, 32-оос дээш шоо метр багтаамжтай думпкар, төрөл бүрийн бутлагч, шигшүүр, конвейер, төрөл бүрийн насос, нар, салхины цахилгаан үүсгүүр	10	8
70	Авто самосвал, дизель генератор, 32 шоо метр хүртэл багтаамжтай думпкар, эрдэс түүхий эд боловсруулах төхөөрөмжүүд, туузан дамжуулагч	9	7
2.3. Ноос боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж			
71	Хялгас ялгах, самнах, ноос сэмлэх, сэгсрэх, зулхай шивэх, эсгий гутал хийх тоног төхөөрөмж	12	10
72	Зүү, кардаар самнах, ээрэх, эрчлэх, давхарлан ороох, ноос, утас хатаах, эсгий, эсгий гутал агшаах, нягтруулах, эсгий гутал уллах, хэвлэх, ноос нэхэх, дугуй сүлжих, нэхмэл эдлэл хийх тоног төхөөрөмж, нэхмэлийн болон туузлах, хивс нэхэх машин, бохир ноос угаах, хатаах агрегат, босоо шахуургат пресс, ноос зөөвөрлөх хийн төхөөрөмж, чийгшүүлэх тоноглол, ноос боловсруулах үйлдвэрийн бусад туслах машин	10	8
73	Сүлжих машин төхөөрөмж	10	8
74	Ноос баглах зориулалт бүхий хэвтээ шахуургат пресс, даахь ураг машин	10	8
2.4. Арьс, шир боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж			
75	Арьсанд механик боловсруулалт хийх, арьс хатаах төхөөрөмж, арьс будах агрегат	10	8
76	Арьс махлах, хуваах, шахах, хусах, сунгах, индүүдэх төхөөрөмж, арьс шир боловсруулахад хэрэглэгдэх барабан, баркас	10	8
77	Нойтон боловсруулалтын туслах төхөөрөмж	10	8
2.5. Оёдлын үйлдвэрийн тоног төхөөрөмж			
78	Бүх төрлийн оёдлын машин, эсгүүр, нэхий, арьс ширний машин, гутлын ул, эсгий үйлдвэрлэх төхөөрөмж, гутал уллах, хэвлэх машин, гутлын хэвлүүр, цавуу, химийн уусмал найруулах төхөөрөмж	10	8
79	Оёдлын үйлдвэрийн гүйцэтгэн боловсруулах ажлын машин, тоног төхөөрөмж	10	8
80	Дамжлага дундын бусад тоног төхөөрөмж	10	8
2.6. Мод боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж			

81	Хатаалгын камер, тунель, кабин, өнгөлгөөний суурь машин, фанерь хуулганы, шүдэнзний, цаас, картоны үйлдвэрийн машин, мод, гуалин буулгах, ялгах төхөөрөмж, модон хийц боловсруулах суурь машин, зоргодос гаргах машин, хавтангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	10	8
82	Халуун, хүйтэн шахуурган хавчаар, хавтан хийц боловсруулах суурь машин, хавтангийн үйлдвэрийн барабан, хатаагуур, дагалдах төхөөрөмж	9	7
83	Хөрөө рам, дагалдах тоноглол	8	5
84	Мод цагаалж ачих трактор, мод тээврийн автомашин, чиргүүл	8	5
85	Дотоод шаталтат хөдөлгүүрт хөрөө	8	5
2.7. Шил, шаазангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж			
86	Түүхий эд шатаах, хатаах зуух, шаазан шатаах зуух	12	10
85	Түүхий эд бутлах, тээрэмдэх, шигших төхөөрөмж, шаазан эдлэлийн масс бэлтгэх машин, шилэн эдлэлд гүйцэтгэн боловсруулалт хийх төхөөрөмж	10	8
86	Шил шарах, уяраах зуух, шилэн эдлэл шахаж хэвлэх автомат	8	7
87	Аяга хэвлэх машин, аяга шатаах шугам, шил хайлуулах зуух, шаазан бүтээгдэхүүн пааландаж угаах шугам	8	6
2.8. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж			
88	Хөргөлт, мал нядалгааны болон саван, жимс, ногооны консерв, талх, нарийн боов, гурил, жигнэмэг, архи, дарс үйлдвэрлэх, өлөн гэдэс боловсруулах тоног төхөөрөмж	10	8
89	Хиам, консерв, гоймон, пүнтүүз, чихэр, сүү, пиво, амтат ус, квас, спирт үйлдвэрлэх, хаягдал, яс боловсруулах машин, тоног төхөөрөмж	10	8
90	Давс боловсруулах, загас олборлох төхөөрөмж	7	5
2.9. Хэвлэлийн үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж			
91	Өндөр хэвлэлийн ротац, том болон дунд форматын хэвлэлийн хавтгай машин, үсэг цутгах, мөрөөр цутгах, цаас нугалах, үдэх болон цуглуулгын машин, цаас хөвж огтлох, хавтас хийх машин	10	8
92	Офсет хэвлэлийн бүх төрлийн машин, тоног төхөөрөмж, мөрөөр өрж цутгах машин, өндөр хэвлэлийн бага форматын хавтгай тигель машин, товхимлын агрегатмашин, цавуун бэхэлгээ хийх, бүх төрлийн огтолгооны машин, блок боловсруулах болон дэвтэрлэгээний иж бүрэн агрегат	10	8
2.10. Хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмж			
93	Зөгийн аж ахуйн тоног төхөөрөмж	14	12
